

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААН



### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-32
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	5-7
2.Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	эргүүлэн татав
3.Өвөлжилтийн бэлтгэл ажил болон намрын ургац хураалтын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох	7-32

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
10 дугаар сарын 03-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл***

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 17 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.*

*Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Г.Дамдинням, Г.Мөнхцэцэг, Ц.Туваан.*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Б.Бейсен, Байнгын хорооны дарга Б.Саранчимэг нар үг хэлэв.

Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас эргүүлэн татав./11:23/

**Б.Саранчимэг:** Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

***Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Саранчимэг, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

**Б.Саранчимэг:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Ц.Идэрбат нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 72.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Өвөлжилтийн бэлтгэл ажил болон намрын ургац хураалтын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, референт Ц.Рэнцэнтогтох, К.Пүрэвсүрэн нар байлцав.

Өвөлжилтийн бэлтгэл ажил болон намрын ургац хураалтын явцын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ц.Идэрбат, Ж.Батжаргал, Б.Бейсен, Г.Тэмүүлэн, Г.Ганболд, Т.Энхтүвшин, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Есөн-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Батжаргал, Т.Энхтүвшин нар үг хэлэв.

Өвөлжилтийн бэлтгэл ажил болон намрын ургац хураалтын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулууны мэдээллийг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 55 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 12 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон  
“Үндсэн хууль” танхим  
11 цаг 17 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Саранчимэг:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 57,9 хувьтай болсон учир Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудлын өмнө гишүүдийнхээ ирцийг танилцуулах ёстой. Улсын Их Хурлын чуулганы энэ хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулах ёстой. Батсүхийн Саранчимэг ирсэн. Цогт-Очирын Анандбазар чөлөөтэй. Тлеуханы Аубакир ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гадаадад томилолттой. Жигжидийн Батжаргал ирсэн. Буланы Бейсен ирсэн байна. Хаянгаагийн Болорчулуун гишүүн ирсэн. Гочоогийн Ганболд ирсэн. Наянтайн Ганибал ирсэн. Гонгорын Дамдинням орон нутагт ажиллаж байгаа, чөлөөтэй. Цагаанхүүгийн Идэрбат ирсэн. Гомтилдоогийн Мөнхцэцэг чөлөөтэй. Нанзадын Наранбаатар ирсэн. Дамдинсүрэнгийн Өнөрболор ирж байгаа. Ганзоригийн Тэмүүлэн ирсэн. Цэвэгдоржийн Туваан чөлөөтэй. Одонгийн Цогтгэрэл ирэх үү, тийм ээ.

Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн ирсэн байна.

Та бүхэнд хэлэлцэх асуудлын дарааллыг асуудлыг танилцуулъя.

1-д, Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Цаглавар батлах тухай.

2-т, Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газар 2022 оны 04 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Тэгээд бид нар Байнгын хороогоороо хэлэлцэх эсэхийг нь шийдэх учиртай.

3-д, Өвөлжилтийн бэлтгэл ажил болон ургац хураалтын явц байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны сайдын мэдээлэл сонсох байгаа.

Тэгэхээр хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Бейсен гишүүнээр тасаллаа. Болорчулуун гишүүн саналаа хэлье. Болорчулуун гишүүний микрофоныг өгье дөө.

**Х.Болорчулуун:** Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Энэ Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төсөл гэж орсон байгаа. Үүнийг татаж авъя. Учир нь Хүнсний хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ингэж явж байгаа Их хурал дээр. Тэгээд энэ дээрээ энэ бүлэг заалт болоод оруулчихъя. Тэгэхгүй энэ нэг хэтэрхий жижигхэн нэг цөөхөн 1, 2, гуравхан зүйл заалтын төлөө бүхэл бүтэн нэртэй хууль орох нь онц шаардлагагүй гэж үзэж байна. Тэгж Хүнсний хуультайгаа нэгдмэл байх нь энэ зүйтэй гэсэн ийм бодолтой байна.

**Б.Саранчимэг:** Бейсен гишүүн саналаа хэлье.

**Б.Бейсен:** Та бүгдэд өглөөний мэнд хүргэе. Энэ өвөлжилтийн бэлтгэлийн ажил дээр сая цас орсон та бүгд мэдэж

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа. Манай аймаг ер нь баруун аймгууд, баруун 5 аймаг ер нь түүн дотор ялангуяа баруун 3 аймгийн өвөлжилт, зуншлага тааруухан болсон. Нэлээн зузаан цас орчихсон байгаа. 9 сарын сүүлээр бүгдээрээ өвөлжөөндөө буучихсан байгаа. Тэгээд энэ талаар ямар арга хэмжээ авах вэ? Жишээлбэл Дэлүүн сумын 1, 2, 3, 10 дугаар багууд чинь мал бэлчих газар өвөлжөөнд ирчихсэн. Толбо сум бүхэлдээ цастай зарим газар бүр 60 см цас орчихсон байгаа. Бугат сум, Улаанхусын тэр 5 богдын дээшээ мөн Цэнгэлд үүнийг өвөлжилтийн юун дээр оруулж ярих уу, яах вэ?

### **Б.Саранчимэг:**

Эхлээд

Болорчулуун гишүүний санал дээр, сайдын санал дээр хэдүүлээ саналаа ярилцъя. Тэгээд зохицуулах үйлчлэлтэй, энэ манай энэ хуулийн төсөл Монгол Улсын Ерөнхийлөгч хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамжийн талаар санаачлаад манай Улсын Их Хурал дээр 36 дугаар тогтоол баталсан. Тэгэхээр энэ 36 дугаар тогтоолын дагуу Хүнс, хөдөө аж ахуйн яам бол бас 8 гаруй хуулийн төслийг оруулж ирэх ёстой. Түүнээс хойш ганц ч орж ирээгүй байна. Манайх энэ дээр нэлээн Улсын Их Хурлынхаа зүгээс хийх ажлаа хийчихсэн, хэлэлцүүлгүүдийг нэлээн зохион байгуулсан. Тэгээд түрүүн анх хэлэлцэхэд бас л татна гээд тэгж байсан. Түүнээс хойш нэлээн олон сар өнгөрчихсөн. Тэгээд бас яамдаас нь санал аваад оруулах юм байна гэж оруулж ирж байгаа. Тэгээд сайд өөрөө ингэж хэлж байгаа учраас тэгээд татаж, энэ хэлэлцэх асуудлаас гаргая. Тэгээд дараагийн удаа дараагийн хурлаас эхлээд нөгөө яг энэ 36 дугаар тогтоолын дагуу оруулж ирэх хуулийнхаа төслүүдийг яаралтай оруулж ирэх хэрэгтэй байна. Хэрвээ энэ дээр бас Байнгын хорооны зүгээс бас ингэж шаардаж ажиллахаа бас хэлэхийг хүсэж байна. Тэгээд ер нь энэ 36 дугаар тогтоолыг хэрэгжилт нь Улсын Их Хурлаар хууль, эрх зүйн орчин нь бүрдэж байж хэрэгжих учиртай. Тэгээд зарим юмнууд нь хэрэгжихгүй байгаа

учраас энэ дээр сайд бас анхаарлаа хандуулж ажиллахыг бас хүсэж байна.

Тэгээд хэлэлцэх асуудлаасаа хасаад явъя.

Тэгэхээр 2 асуудалтай болж байна.

Тэгэхээр Байнгын хорооны тогтоолын төсөл цаглавар батлах тухай нэг. Хэлэлцэх асуудлаа баталъя гэсэн хүн гишүүд кнопоо даръя.

Санал хураалт. 2 хэлэлцэх асуудал батлагдлаа.

**“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Та бүхэнд цаглаварууд тарж очсон байгаа.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн энэ тухай хуульд заасны дагуу энэ Улсын Их Хурлын дарга 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай ийм 148 дугаар захирамжийг баталсан байгаа. Тэгэхээр энэ хуралдааны дэгийн тухай хуульд энэ дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороо баталж мөр бүрдүүлнэ гэж заасны дагуу бид нар өнөөдөр энэ цаглаварыг батлах гэж байна.

Тэгэхээр Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж саналтай гишүүд нэрсээ өгье.

Тэгээд зохицуулах үйлчлэлийн цаглаварт. Цагалбар дээрээсээ энэ Зохицуулах үйлчлэлийн тухай хуулиа

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хасаад ингээд цаглавараа батална гэсэн үг. Тэгэхээр цаглавартай холбогдуулж саналтай гишүүд, 2 гишүүн байна. Бейсен гишүүн саналаа хэлье.

**Б.Бейсен:** Миний саяын ярьсан санал дээр энэ өвс тэжээлийн асуудлыг эрт бэлдэхгүй бол үүнийг цаглавартаа оруулахгүй бол ноднин манай аймагт нэг пресс өвс 45 мянга, хорголжин юу чинь 80 мянга хүрсэн шүү дээ. Одоо өвөлжөөндөө 9 сарын сүүлээр буучихсан болохоор чинь бараг уултай газраа мал бэлчих нөхцөлгүй болсон. Тийм учраас энэ өвс тэжээлийн асуудлыг Сэлэнгэд талдаа бас ярьсан эрт татаж авах тэр аймгийн удирдлагууд дээр бас хэлсэн байгаа. Энэ асуудлыг энэ баруун 3 аймаг дээр чинь өвс тачирхан ургадаг. Мал бэлчих өвөлжих ямар ч боломжгүй болж байна. Одоо өвөлжөөнд бууж байгаа юм чинь тэгээд хавар хүртэл яахгүй. Тийм учраас өвс тэжээлийн асуудлыг эрт бэлдэх тал дээр энэ юун дээр бас оруулж өгөөч гэсэн санал байна.

**Б.Саранчимэг:** Өвөлжилтийн байдлаар яг салбарын сайд Болорчулуун сайд мэдээлэл хийх учиртай. Тэгэхээр энэ дээр бас нэг Болорчулуун сайдад нэг тайлбар өгчих үү. Бейсен гишүүний асуултад.

**Х.Болорчулуун:** Баян-Өлгий аймагт харин цас нэлээн орсон сураг байсан. Тэгээд өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах нь сум, аймгийн үүрэг байгаа шүү дээ. Түүнээс Хөдөө аж ахуйн яамнаас бодлогын ажил явахаас биш яг өвөлжилтийн бэлтгэлийг хангах дээр шууд тусгайлан хөрөнгө мөнгө зарах асуудал огт байхгүй.

**Б.Саранчимэг:** Бейсен гишүүн тодруулъя.

**Б.Бейсен:** Энэ асуудлыг уг нь сайд аймгийн удирдлагууд дээр эртхэн шиг яахгүй бол байдал хүндэрнэ шүү. 9 сарын сүүлээр өвөлжөөндөө буучихсан гэдэг чинь энэ ноднин чинь бүх зээл авсан малчид тэгээд байдал нь нэлээн хүнд

байгаа шүү. Энэ асуудлаар нэлээн онцгой анхаарахгүй бол тэгээд л хүндэрнэ шүү. Энэ асуудал дээр УОК-т хэлж байгаад ер нь өвс тэжээлийг татаж авах асуудлыг эртхэн шийдэхгүй бол ерөөсөө болохгүй юм байна лээ.

**Б.Саранчимэг:** Болорчулуун гишүүн нэмж хариулъя.

**Х.Болорчулуун:** Нэмж хариулахад бас ингээд Дорнодын зарим хэсэг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаанд өвс Хятадын хөрөнгө оруулалттай компани Хятадууд бүр техник оруулаад ихээр хадсан байсан. Энэ энэ тэрийг бол Сүхбаатар, Дорнод аймгийн дарга нар луу бичиг өгч гарахыг хориглосон байгаа. Гааль руу бичиг өгсөн байгаа. Ер нь бид нар дотооддоо л энэ өвсөө хэрэглэхээс биш гадагшаа экспортлоод байх ямар ч шаардлагагүй. Тэгээд өвс чинь угаасаа нэг өвсөн дээр нэг айхтар Монгол Улс ашиг олоод экспортлоо гээд яах юм байхгүй.

3 дугаарт бас өвс хэт их ингэж хавтгай хадах нь гаднын хөрөнгө оруулалттай компани оруулаад хадах нь зээрийн экологийн байдалд шууд нөлөөлчих юм. Тэгэхээр энэ өвсний явдал гадагшаа гаргахгүй болохоор дотооддоо л хангалттай хүрэлцэх байх гэсэн ийм л бодлого байна.

**Б.Саранчимэг:** Та тэгээд бас мэдээлэл дээр Бейсен гишүүн илүү тодруулаад асуучхаарай.

Идэрбат гишүүн цаглавартай холбогдуулж асуулт саналаа хэлье.

**Ц.Идэрбат:** Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд энэ Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг гэж. Тэгээд энэ асуудлыг аль өнгөрсөн 6 сард 5 сарын тэр цаг уурын хүндрэл, энэ хаврыг арай чамай давсан малчидтай уулзаад тэгээд малчдаас гарч байгаа

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

санал бол энэ малын даатгалын асуудал дээр бас эргээж харах зайлиггүй зохицуулалтууд хэрэгтэй байна гэдэг дээр бас олон хүн саналаа хэлсэн учраас энэ Байнгын хороонд танилцуулаад ингээд нэг ажлын хэсэг байгуулагдах болоод ингээд явсан. Тэгээд энэ бас их би хариуцлага л ярих гээд байна л даа. Энэ аль 6 сарын 20 хэдэнд ярьсан юмыг ажлын хэсэг нь 10 сарын 31-нд гэж ингээж тавигдаж байгаа байхгүй юу. Үгүй ээ, ийм хөгийн баймааргүй байна аа, энэ чинь ажил ажил шүү дээ, энэ. Үнэхээр ажлын хэсэг байгуулагдсан бол ажлын хэсэг нь энэ 4, 5 сарын хугацаанд юу хийж байдаг юм. Одоо тэгээд бүр дараагийн өвөл, хавар, хаврын хүндрэл яригдах үед ажлын хэсэг нь 10 сарын 31-нд гэж ингээж энэ хуваарь дээр тавигдсан байна л даа. Тэгээд энэ дэд ажлын хэсэг эд нар гэж байгуулагдсан юм уу. Тэгээд энэ ажлын хэсэг нь эхний хурлаа хийгээгүй байх гэж би бодож байна. Тэгээд бүхэл бүтэн хагас жилийн дараа бараг үүнийг ярих болж байгаа юм. Би бол ийм хариуцлагагүй баймааргүй санагдаж байна. Үүнийг чинь тухайн үед хавар яригдаад олон малчин үүний ар дээр чих тавиад хүлээгээд сууж байгаа байхгүй юу. Нэг юм яригдлаа даа, одоо үүнийг нь бас нэг өөрчилбөл өөрчлөхөөр байна. Одоо шууд даатгал авдаг болох уу яах вэ гээд.

Тэр Байнгын хорооны хурал дээр Мөнх-Оргил гишүүн байсан. Энэ хуулийг бас батлалцаж байсан хүн юм байна лээ шүү дээ. Тэгээд анхны бидний гаргасан тэр үзэл баримтлалаас бас жоохон хазгай болсон юм байна шүү. Энэ давхар даатгалын асуудал дээр олон асуудлууд байгаа юм байна шүү гээд ингээд. Би энэ дээр энэ ажлын хэсгийн энэ хурлыг бүр 10 сарын эхээр тавимаар байна. Малчдын өмнө очиж юу хэлэх юм бэ. 6 сард ярьсан асуудлыг 11 сард ярих гэж байна.

Тэгэхээр ер нь Байнгын хороо энэ ажлын хэсэг энэ тэр байгуулагдаад ингээд байгаа бол жоохон араас нь ажил хэрэгч баймаар байна. Тэр байгуулсан ажлын хэсэг нь ажиллах юм уу үгүй юм

уу. Ажиллахгүй бол татан буулгаад. Ажиллавал ажилладаг тийм горим руугаа ормоор байна шүү дээ. Бүхэл бүтэн 5 сарын дараа асуудал яригддаг юм гэж би энэ төрийн ажил хийж байхад анх удаа л харж байна. Ийм замбараагүй. Тэгээд үүнийг би 10 сарын 30 биш энэ ажлын хэсэг дэд ажлын хэсэг нь хурдан хуралдуулмаар байна.

### **Б.Саранчимэг:**

Идэрбат гишүүнтэй бас санал нэг байна. Тэгэхээр бид нар удирдамжаа манай Байнгын хороо хийх ажлаа хийгээд удирдамжаа батлаад өгсөн. Дэд хэсгүүд, ажлын хэсэг байгуулагдчихсан байгаа. Өнөрболор гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Тэгээд дэд хэсэг нь хуралдаж байж, ажлын хэсэг хуралдах ёстой. Тэгэхээр үүнийг бас манай ажлын Байнгын хорооныхон Өнөрболор гишүүнд хэлээд үүнийг дэд хэсгийг нь энэ удаа хуралдуулаад, дараагийнхаа ажлын хэсгийг нь яг энэ ирэх 7 хоногтоо багтаагаад хуралдуулах ийм үүргийг өгч байна.

Эхний цаглавартай холбогдуулж саналаа хэлж, асуултаа асуусан гишүүдэд баярлалаа.

Тэгэхээр цаглавраа энэ удаагийн цаглаврыг баталъя гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Энэ гацаад байна гэж байх юм.

Болорчулуун, Идэрбат гишүүн протоколд оруулаарай. Цаглаврыг баталсан гэдгээр дэмжсэн гэж байгаа.

Гишүүдийн олонх дэмжсэн учир цаглавар батлагдлаа.

11.33 цаг

Дараагийнхаа асуудал руу орёе.

**Өвөлжилтийн бэлтгэл ажил болон ургац хураалтын явц байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн**



2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох ёстой байгаа.**

Тэгэхээр ажлын хэсгийнхнийг дуудаад оруулчхаарай. Мэдээллийг сайд хийнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ирсэн ажлын хэсгийнхнийг бас та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Х.Болорчулуун ХХААХҮ-ийн сайд, Ц.Болорчулуун мөн яамны Бодлогын төлөвлөлтийн газрын дарга, Г.Наранчулуун яамны МАА-н бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Есөн-Эрдэнэ мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга.

Болорчулуун сайдыг мэдээллээ хийхийг урья. Болорчулуун сайдын микрофоныг өгье.

**Х.Болорчулуун:** Баярлалаа. Хөдөө аж ахуйн салбарын 23-24 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 279 дүгээр тогтоол, хөдөө аж ахуйн салбарын 23-24 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил эрчимжүүлэх тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 03 дугаар албан даалгаврыг гаргуулан аймаг, нийслэлд хүргүүлэн ХХААХҮ-ийн сайдын 23 оны А499 дүгээр тушаалаар МАА-н салбарын 23-24 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил хангах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах чиг үүрэг бүхий ажлын хэсэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

23 оны зунилага нийт нутгийн 60 гаруй хувьд нь зунилага сайн, 30 орчим хувьд нь дунд, 10 орчим хувьд нь муу гэж үнэлэгдсэн. Харин 23-24 оны өвөл, хаврын бэлчээрийн даац 50 орчим хувьд нь хүрэлцээд, 50 гаруй хувьд нь даац

хэтэрсэн судалгаа гарсан. Бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх зорилгоор 23 оны хаврын улиралд 8 аймгийн 46 сумын 120 гаруй мянган га-д микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулсан нь бэлчээрийн ургамлыг ургаж эхлэх үед мэрэгч амьтан хөнөөлд өртгөөс сэргийлж, цаашилаад бэлчээрийн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх боломж бүрдлээ.

Улсын хэмжээнд 23 оны онд 18,1 сая толгой төл хүлээн авч, 5,1 сая толгой малыг дотоодын хэрэгцээнд, 12 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулан, 62,8 сая толгой мал өвөлжиж, хаваржиж, урьдчилсан дүн мэдээтэй байна.

Засгийн газрын 23 оны 279 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, сум, дүүрэгт аюулгүй нөөц бүрдүүлбэл зохих өвс тэжээлийн хэмжээг тогтоон хүргүүлсэн. Тус тогтоолын хүрээнд аймаг, сумын аюулгүй нөөц 21 мянган тонн өвс, 12 мянган тонн тэжээл бэлтгэхээс одоогийн байдлаар аймаг, сумын аюулгүй нөөцөд 2100 тонн өвс, 425 тонн тэжээлийг бэлтгээд байна. Аймгууд тендер зарлах гэрээ байгуулах шатдаа байгаа.

Энэ онд улсын хэмжээнд малчдын түвшинд 23 онд 9 сарын 29-ний өдрийн байдлаар 696 мянган тонн өвс, 232 2 мянган тонн сүрэл, 7,8 мянган тонн ногоон тэжээл, 2,5 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 15,4 мянган тонн гар тэжээл, 534 тонн дарш, 19,5 мянган тонн хужир, шүүг бэлтгэж малчдын түвшин өвс тэжээлийн бэлтгэл 42,8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ онд орон нутгийн хөгжлийг дэмжих “шинэ хөдөө” төсөл арга хэмжээний хүрээнд хадлангийн тоног төхөөрөмж дэмжлэг үзүүлэх зорилгоор Төв аймагт 5, Булган аймагт 3 хадлангийн иж бүрдлийг бүр нийлүүлээ.

Энэ онд улсын төсвийн 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 21 аймгийн 87 сумдад инженерийн хийцтэй 99 худаг

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шинээр барьж ашиглалтад оруулснаар 297 мянган орчим мал сүргийг усаар хангах ажлыг зохион байгууллаа.

23 онд улсын төсөв болон төсөл хөтөлбөрийн 521 сая төгрөгийн хөрөнгөөр хөдөө аж ахуйн халхавч үндэсний бүтээн байгуулалтын бүсийн тусгай хэрэгцээний газарт ус цэг тогтоох, хайгуул судалгаа хийх, инженерийн хийцтэй 8 худаг шинээр барьж, 30 мянга үхрийг усаар хангаснаар мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрийн бүс дэх малыг найдвартай чанартай усны эх үүсвэрээр тогтвортой хангах боломжийг бүрдүүлж эхэллээ.

“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд Дорнод, Сүхбаатар, Ховд, Завхан аймгийн 30 сумын 105 бэлчээрт ус цэг тогтоох хайгуул судалгааны ажил явуулж шинэ худаг гаргах нөөц цэгийн тоог нэмэгдүүлэв.

23 он гарсаар мал амьтны гоц халдварт өвчний 192, голомт шүлхий 2, бог малын 110, хонины цэцэг 75, үхрийн арьс товруутах 1, гахайн африкийн мялзан 4 бүртгэгдсэн. Өнөөдрийн байдлаар мал амьтны гоц халдварт өвчний улмаас 3 аймгийн 4 суманд 4 голомт хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм үргэлж байна. Тухайлбал, бог малын мялзан өвчин Булган аймгийн Бүрэгхангай, Хишиг-Өндөр суманд 2 голомт, гахайн африкийн мялзан Архангай аймгийн Эрдэнэбулган суманд 1 голомтод хорио цээрийн дэглэмтэй, хонины цэцэг өвчин Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд 1 голомт хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байна.

Харин малын гоц халдварт шүлхий өвчнөөр манай улс тайван байна. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг нийт 18 сая толгой мал хамруулахаас 73452 малчин өрхийн 17,6 сая толгой мал

хамруулж, 92,8 хувийн гүйцэтгэлээр хийгдсэн.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 5,5 сая толгой мал амьтан хамруулахаас 143500 малчин өрхийн 5,1 сая толгой мал амьтан хамруулж, 92,4 хувийн гүйцэтгэлээр хийгдсэн.

Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 4,6, хонь 1,8 мянган толгой, хурга 2,8 мянган толгой сая богийг хамруулахаас 13800 малчин өрхийн 3,6 сая толгой мал, хургыг хамруулж, 80 хувийн гүйцэтгэлтэй тарилга хийгдээд байна.

2-т, ургац хураалтын явцын талаар

Тариалалтынхаа санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тариалалт хураалтыг технологийн хугацаанд явуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор Хүнсний хангамж аюулгүй байдлын үндэсний хөдөлгөөн, Засгийн газрын 23 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд арилжааны 10 банкттай гэрээ байгуулан тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 641 иргэн, аж ахуйн нэгжид 87,9 тэрбум, жимс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 552 иргэн, аж ахуйн нэгжид 21,6 тэрбум, нийтдээ 109,5 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна.

Мөн хөрөнгө оруулалтын зээлийн эх үүсвэрээр 175 иргэн, аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй 67,4 тэрбум төгрөгийн зээлийг зорь, хүлэмжийн аж ахуйн услалтын систем, үтрэм байгуулах техник тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулсан.

Хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит компанийн 7 салбарын агуулахад мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваржуулалт, шаардлагын элеваторын хатаалга, авто пүү, цэвэрлэгээний тоног төхөөрөмжийн

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

засвар үйлчилгээг хийж, ургац хүлээн авах бэлтгэлийг бүрэн хангах, улаан буудайн хүлээн авах ажил эхлээд байна.

“Хүнсний хангамж аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолоор жил бүрийн ургацаас стратегийн нөөц бүрдүүлж байхаар шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн корпорац шинэ ургацаас худалдан авалтаар 21 мянган тонн, өр авлагад 34 мянган тонн, нийт 55 мянган тонн хүнсний улаан буудай, 10 мянган тонн орчим үрийн улаан буудайн нөөцийг тус тус бүрдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Мөн элеватор агуулах түрээслэх хүсэлтэй гурилын үйлдвэртэй элеватороор түрээслэх гэрээ байгуулан ажиллаж байгаа. Тариалангийн салбарт бордооны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хөрсний үржил шимийг хамгаалах, шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын хэмжээг нэмэгдүүлж чанарыг сайжруулах зорилгоор бордоо худалдан авсан иргэн, аж ахуй нэгжид ашигласан бордооны үнийн 30 хувь хүртэлх хувийг татаас хэлбэрээр буцаан олгохоор төлөвлөж, шаардагдах 3,9 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн. Засгаар.

Өнөөдрийн байдлаар буцаан олголтод хамрагдах хүсэлт ирүүлсэн нь 25 иргэн, ААН-ийн хүсэлтийг цахимаар хүлээн аваад байна. Ургацын урьдчилсан балансаар нийтдээ 510 мянган тонн үр тариа үүнээс 480 мянган тонн улаан буудай, 165 мянган тонн төмс, 166 мянган тонн хүнсний ногоо, 65 мянган тонн тосны ургамал, 225 мянган тонн малын тэжээлийн ургамал, 5 мянган тонн жимс жимсгэнэ хураан авах боломжтой төлөв гарсан. Балансыг өнгөрсөн жилийн ургацтай харьцуулбал улаан буудайн үйлдвэрлэл 70 мянган тонн буюу 17 хувиар, хүнсний ногооны үйлдвэр 26 мянган тонн буюу 18,3 хувиар, малын

тэжээл 67 мянган тонн буюу 42 хувиар тус тус өсөхөөр баланс гарсан.

Ургац хураалтын одоогийн явц нөхцөл байдлын талаар хэлэхэд 23 оны 9 дүгээр сарын 29-ний байдлаар 28,6 мянган га-аас 3,9 мянган тонн үр тариа үүнээс 26,4 мянган га-аас 34,8 мянган тонн улаан буудай, 9,2 мянган га-аас 82 мянган тонн төмс, 6,6 мянган га-аас 7,9 мянган тонн хүнсний ногоо, 20 мянга га-аас 35,8 мянган тонн тэжээлийн ургамал, 9 мянга га-аас 3 мянган тонн тосны ургамал тус тус хураан авч, хураалтын явц үр тарианы тарималд 9 хувь, төмс 51 хувь, хүнсний ногоо 50 хувь, тэжээл 18 хувь, тосны ургамал 5 хувьтай явагдаж байна.

Хур бороо ихтэй үе үе бороо орж байгаагийн улмаас ургац хураалтын ажил технологийн хугацаанаас даруй 14-15 хоноогоор хойшилсон тул ургац хураалтад анхаарах технологийн зөвлөмжийг Дархан-Уул аймаг дахь ургамал газар хилийн хүрээлэнтэй хамтран боловсруулж тариаланчид хүргүүлсэн.

9 сарын 25-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус хуралдаанд ургац хураалтын явцын талаар танилцуулга хийсэн бөгөөд улмаар ургац хураалтыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулахад Улсын ургацын комиссын гишүүд хариуцсан салбарынхаа чиглэлээр анхаарал хандуулж, салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайтар ханган ажиллах талаар албан даалгавар гаргаж, комиссын гишүүдэд чиглэл үүрэг өгч хүргүүлэн ажиллаж байгаа болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Саранчимэг:** Болорчулуун сайдад баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулж асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Наранбаатар гишүүн асуултаа асууя.

**Н.Наранбаатар:** Байнгын хорооны гишүүдэд өглөөний мэнд хүргэе.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Өвөлжилт, хаваржилттай холбоотой сайдын мэдээллийг сонслоо. Сая гишүүд тойрогтоо ажиллалаа. Миний бие бас сонгогдсон тойрог Өмнөговьд ажилласан. МАА өвөлжилтийн бэлтгэл ажил дээр онцгой анхаарахгүй бол болохгүй байна. Энэ жил ер нь говь нутгаар Өмнөговь, Дорноговь, ер нь говийн нутгуудаар ерөөсөө бороо хур муутайгаас зуншлага тааруу, гантай. Түүнийгээ дагаад өвөлжилт, хаваржилт хүндрэх ийм нөхцөл байдал харагдаж байна. Манай аймгийн хувьд 2,6 сая тооны малтай, 6500 малчин өрхтэй байна. Одоогоор отор нүүдэл хийгээд эхэлсэн. Өөрийн залгаа аймаг Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь аймгуудад, мөн аймгийнхаа бусад сум доторх сумдын нутгуудаар ингээд отор нүүдэл хийгээд эхэлсэн ийм байдалтай байна.

Яамны зүгээс энэ МАА өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тал дээр ямар ажлууд ер нь бодлогын түвшинд, үйл ажиллагааны түвшинд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм. Тухайлбал отор нүүдлийг зохицуулах тал дээр урьд урьд жилүүдээс шинэлэг зүйл юу байна. Эхнээсээ нүүгээд очсон малчдыг хөөх, туух, өвөлжөө бууцаа өндөр үнээр ашиглуулах, худаг усаа харамлах ашиглуулахгүй байх зэрэг асуудлууд гараад эхэлсэн байж байгаа. Малчид маань малаа ер нь борлуулъя, хэдэн төгрөгтэй болъё, өвс тэжээл авъя гэдэг асуудал ярьж байна. Өвс, тэжээлийн үнэ бас өнгөрсөн жил өндөр байсан. Энэ дээр энэ жил зохицуулах ямар нэгэн өвс, тэжээлийн үнэ дээр зохицуулах боломж байна уу? Хадлан ер нь хэр авч бэлдэж байгаа вэ?

Малчид малаа борлуулах боломж бас хомс байна. Энэ дээр яамны зүгээс ялангуяа дундаас доош тарга хүчтэй малыг борлуулах дээр анхаарал тавьж байгаа зүйл байна уу?

Мөн дээрээс нь арьс шир, ноосыг борлуулахад нь малчдад дэмжих туслах ямар боломж байна? Ер нь онд орохгүй

буюу дундаас доош тарга хүчтэй малаа борлуулах, арьс шир, ноосоо борлуулж бас 5 төгрөгтэй болох тэжээд үүгээрээ бас хямд төсөр үнэтэй өвс тэжээл худалдаж авах зэрэг асуудлуудыг л малчид маань ярьж байна. Тийм учраас энэ дээр яамны зүгээс энэ жил ямар ажлуудыг төлөвлөж хийхээр бэлдэж байгаа вэ гэсэн асуулт байна.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Өвөлжилтийн бэлтгэлд нь хамгийн гол нь өвс, тэжээлээ бэлтгэх нь юу юунаас чухал. Энэ жилийн хувьд өнгөрсөн жилтэй харьцуулахад ногоон тэжээл 42 хувиар илүү тариалж, тийм хэмжээгээр ургац авах ийм боломж бас нээгдээд байгаа. Одоогоор өвсний хадлангийн байдал 43 хувьтай явж байна. Зарим жилүүдтэй адилхан хадлангийн өвсийг гадагшаа гаргахыг хязгаарласан ийм бодлого баримталж ажиллаж байна. Энэ өнгөрсөн намар Засгийн газраар бүх төрлийн арьс ширийг гадагшаа чөлөөтэй гаргахыг Засгийн газрын тогтоолыг ХХААХҮЯ-наас оруулж батлуулсан байгаа. Ингэснээрээ энэ намрын хайрцаглалт гадагшаа ахиад Турк улс руу нэлээн гаргах байх гэсэн ийм ерөнхий төлөвтэй байгаа.

Нэмээд Наранчулуун дарга хариулна.

**Б.Саранчимэг:** 1 дүгээр микрофоныг ажиллуулъя. Наадах чинь өөрөө гэрэл асгах ёстой доо.

Сайн байцгаана уу. ХХААХҮЯ-ны МАА-н бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Наранчулуун байна. Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Отор нүүдлийг энэ жил Засгийн газрын тогтоол болон Ерөнхий сайдын албан даалгаврын хүрээнд босоо чиглэл буюу бүс дамнахгүй байдлаар зохицуулахаар үүрэг чиглэл өгөгдсөн

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа. Энэ нь 1 дүгээрт, малын өвчлөлийг хөлийн малын хөдөлгөөнөөр хязгаарлахтай холбоотой энэ асуудлууд яригдсан.

Өмнөговь аймаг энэ жилийн хувьд хамгийн зан зунилага муутай. Ер нь 3 жил дараалан гандсан хамгийн хүнд, хүндрэх аймгуудын нэг гэж тооцоолж байгаа. Бид нар өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнг 10 сарын 25-нд авсны дараа гамшигийн эрсдэлийн үнэлгээг Дорноговь, Өмнөговьос эхлээд хийнэ гэсэн ингээд төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Энэ жилийн тухайд 17 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулна. Үүнээс 12 сая малыг нь дотоодын хэрэглээнд 5-ыг нь экспортод чиглэж бэлтгэнэ гэсэн төлөвлөгөөтэй байна.

Маргаашийн Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр махны экспортын квотын асуудлыг ярилцаж шийдвэрлэх юм.

Өвс тэжээлийн үнийг нь бид нар мэдээж зохицуулж чадахгүй. Аль болох дотоодынхоо хэрэгцээг хангахын тулд сайд сая хэллээ. Өвс тэжээлийн экспортыг хязгаарласан байгаа. Мөн арьс ширийг ч гэсэн чөлөөтэй гаргах шийдвэрийг 22 оны 12 сарын сүүлээр гаргасан учраас энэ жилийн мах бэлтгэлээс энэ асуудал маань хэрэгжиж эхэлнэ гэсэн ийм байдалтай байна.

**Б.Саранчимэг:** Наранбаатар гишүүн тодруулъя гэж байна.

**Н.Наранбаатар:** Энэ Замын-Үүдээр бог малыг хөлөөр нь экспортод гаргаж байгаа шүү дээ. Энэ дээр хэдий хэмжээний мал гаргачхаад байгаа юм. Энэ жил, цаашид он дуустал хэдий хэмжээний мал гаргах юм. Ер нь энэ яаж ААН-үүд ямар квотоор аймгуудаас яаж аваад байгаа юм. Ер нь малчдад нэг мэдээлэл өгөх шаардлагатай юм шиг харагдаад байгаа юм.

**Б.Саранчимэг:** 1 номерын микрофоныг өгье. Наранчулуун даргын микрофоныг.

**Г.Наранчулуун:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Замын-Үүдээр 22 оны 10 сарын 15-наас он дуустал 25 мянган бог гарсан байгаа. Он гараад 2 сарын 15 хүртэл 28 мянга, үндсэндээ 22-23 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 53 мянган мал гарсан. Энэ жил 9 сараас эхлээд гарч эхэлж байна. Өнөөдрийн байдлаар 20 мянган толгой гарч байна. Энэ ер нь бид нарын санаж байгаа, хүсэж байгаагаар бол ядаж хамгийн багадаа 1 сая мал гаргах юм сан гэж хүсэж байна. Гэвч боомтын хүчин чадал тэр хэмжээнд ганцхан боомтоор гарч байгаа учраас хүрэхгүй. 500 мянга хүрч чадвал бид нар бас нэлээн ажил мөнгө болгочихлоо. Малаа эдийн засгийн эргэлтэд оруулчихлаа гэж тооцохоор байна. Квотын тухайд 2 ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Минут нэмж өгье дөө. Гүйцэд хариулах болохоор 1 минут.

**Г.Наранчулуун:** Хоёр, гуравхан компани нь нэг 20, 30 мянган толгойг л зөвшөөрөл авсан байгаа. Ямар нэгэн байдлаар хүсэлт тавьж байгаа компаниудад бид нар татгалзахгүй байгаа. Болж өгвөл 1 саяыг хүргэчих юм сан гэсэн сан бодолтой байгаа.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Идэрбат гишүүн асуултаа асууя.

**Ц.Идэрбат:** Энэ жилийн зунилага бас харьцангуй гайгүй, өвөл, хавар бас аятайхан болох байх аа гэсэн ийм бас чигтэй байгаа юм байна. Тэгээд отор нүүдлийн асуудал дээр 1 дүгээр асуудал энэ отор нүүдлийг босоо чиглэлд явуулна аа гээд яах вэ тийм шийдвэр гарсан л гэж байна. Тэгээд яг хэрэгжилтийг нь ер нь яг яаж хангах юм бэ? Үүнийг хэрэгжүүлэхгүй байвал ямар хариуцлага, асуудлууд яригдах юм бэ? Яг нэг босоо чиглэлийн энэ отор нүүдлийн асуудлыг

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хариуцаад ажиллах хүн хүч, хөрөнгө мөнгө энэ бүх юмнуудаа яам бас ишийдсэн юм уу? Зүгээр л цаасан дээр босоо чиглэл байх ёстой л гээд л. Тэгээд амьдрал дээр энэ чинь бас хэрэгждэггүй гэдгийг та ч мэдэж байгаа, би ч мэдэж байгаа шүү дээ. Хэрэгжүүлэхэд ч хэцүү. Тэгэхээр үүнийг хэрэгжүүлэх хүн хүч, санхүүгийнхээ асуудлыг хэрхэн яаж төлөвлөж байгаа юм бэ гэж 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт, энэ махны экспортын асуудал дээр квот гээд маргаашаас бас яригдах юм байна. Ер нь энэ боомтоор амьд мал гаргаж байгаа дээр янз янз л юм байна. Яах вэ орон нутагт ажиллаж байхад энэ ямаа гаргалаа, ноолуур болохоо болилоо энэ тэр гээд л Хөдөлмөрийн баатар Сампил гээд л хүн бас бүр зориуд хэлээрэй гэснийг би бас уламжилж байгаа юм. Ер нь ингээд нэг л боомтоор нэг л ААН тэгж гаргаад байх юм уу эсвэл цаад БНХАУ-тай өшөө боомт нэмэх ийм асуудлууд ер нь яг ямар шатанд яригдаж байгаа юу, үгүй юү? Одоо экспортынхоо малыг нэмэхийн тулд.

3-д нь, энэ хоршоодыг маш ихээр дэмжиж байгаа. Хоршоод энэ ноос ноолуурыг авч байгаа, хажуугаар нь зэрэгцээд ченжүүд ч авч байгаа. Тэгэхээр надад бас нэг гомдол ирээд байгаа нь хоршоод ингээд авчихаар биднээс 1 хувийн татвар нэхээд байна. Бид татвар төлдөггүй хүмүүстэй өрсөлдөж авсан учраас татварыг нь өгөх боломжгүй болчихоод байна гэсэн нэг ийм зүйлийг яриад байх юм. Тэгэхээр энэ дээр бас ХААЯ янз янзын энэ асуудал дээр та бүхэнд санал хүсэлтүүд ирсэн үү? Хоршоог нөгөө ноолуур авсан хоршоод байгаа шүү дээ. Тэд нар нөгөө ААН-үүддээ ноолуураа тушаагаад ингээд явахаар нэг татварын асуудлууд яригдаад байна. Тэгэхээр нөгөө яг үндэсний үйлдвэрлэлдээ өгсөн татвар төлөөд, ченжүүдэд өгсөн татвар төлөхгүй байна гэсэн ийм зүйлийг бас над руу бас Хэнтий аймгаас хүмүүс явуулаад байна л даа. Одоо удахгүй бас

ямар руу тэр бичиг сачиг болох л юм шиг байна.

Тэгээд ийм 3 асуудал дээр л хариулт авъя гэж ингэж бодож байна.

**Б.Саранчимэг:** Маш тодорхой асуулт асуулаа. Эхлээд салбарын сайд Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Бид нар энэ малыг эргэлтэд оруулахад бэлчээрийн даац бас нэлээн хэтрэлттэй байна. Бүх л талаар түүхийгээр нь, чанаснаар нь, бас амьдаар нь ийм гаргах бодлого яам баримталж ирсэн. Гэхдээ амь мал дээр бас нэлээн нийгэм 2 тал болдог. Малчид аль болохоор амьдаар нь гаргаж, түргэн шуурхай хил залгаа бүс нутгийнхан амьдаараа өгөөд гаргуулчих ийм сонирхолтой байдаг. Зөвхөн нийслэл рүү борлуулалт хийхгүйгээр. Зарим хүмүүс ялангуяа махны холбооныхон, махны үйлдвэрийнхэн амьд мал огт гаргахгүй байх нь хэрэгтэй гэсэн ийм бодлоготой ажилладаг. Гэхдээ амьд малыг бид нар гаргалаа гэхэд нийт бог малынхаа 5 хувьд ч хүрэхгүй, 3 хувьд ч хүрэхгүй гаргаж байна. Бас тодорхой хэмжээгээр бог мал гаргах нь бас энэ үйлдвэрүүдийн бас идэвхийг нэмэгдүүлэх, энэ зах зээлээ нэмэгдүүлэх тал дээр ялангуяа малчдынхаа амьдрал, орлогыг дээшлүүлэх дээр хэрэгтэй байна л даа. Зах хязгаар нутгийн аймгийн малчид дээр. Одоогийн байдлаар зөвхөн Дорноговиор гаргаж байгаа. Ер нь цаашидаа баруун, зүүн аймгуудаар 2 боомтоор бас амьд гаргах асуудал бас яригдаж байгаа. Тэгэхгүй бол зөвхөн борлуулалтыг бүр баруун хязгаараас л нийслэлд хийж байна шүү дээ. Энэ өөрөө малын үнэд, махны үнэд энэ тээврийн зардал маш их шингэж бас малчдын орлогыг бууруулахад нөлөөлж байна гэж бас үзэж байгаа.

Тэгэхдээ энэ дээр бас амьд мал гаргахад гаргая гэсэн аж ахуй болгонд бас Зөвшөөрлийн тухай хуулиар хориглоогүй бол олгоно оо гэсэн байдлыг гаргах нь учир дутагдалтай юм байна лээ. Яагаад гэвэл

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

цаад талдаа боомт дээр Хятад чинь бодлоготой нэг л үйлдвэр байдаг. Тэр үйлдвэрт хэтэрхий олон компани өгнө гэж авбал үнийг нь унагах юм уу бодлого алдагдах юу байна. Үүнийг бас Хятадын талтайгаа холбож бас энэ зөвшөөрөл энэ амьд мал гаргах байдлыг ажиглахгүй болохгүй юм байна гэсэн ийм бас амьдрал дээр яг харагдаж байгаа гэдгийг бас хэлье.

20 онд хэд хэдэн ААН авсан байна. 10 ААН, энэ Бит Монголиа-аас гадна. Тэгсэн мөртөө нэг нь ч гаргаагүй. Шинээр амьд малын юу бол одоогоор квот гэх юм уу зөвшөөрөл олгоогүй байгаа гэдгийг бас хэлье, тусгай зөвшөөрлийг.

2 дугаарт, тэр яах вэ босоо чиглэлд буюу отор нүүдлийг хийх буюу аймаг дамжихгүй аймгаас аймаг дамжихгүй ийм чиглэлийг баримталж, Хөдөө аж ахуйн газраар дамжуулж бас аймгуудад хүргүүлээд байгаа. Энэ малын өвчлөл ялангуяа 2 жилийн өмнө 21 аймагт шүлхий энэ тэр өвчин гарсан. Бог малын өвчин, мялзан энэ тэр дэлгэрсэн бол энэ отор нүүдэлтэй шууд холбоотой. Яг амьдрал дээр тэндээс оторлож ирээд л манай энд өвчин дэлгэрсэн гэсэн асуудал ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ отор нүүдэл дээр ийм бодлого баримтлахгүй бол хангай газрын мал говьд очоод, говийн мал хангай газар, говь талын мал хангай газар очоод тэр хужир шүү, ус, бэлчээр нь бүгд өөр болохоор тэр тодорхой малын дархлаанд нөлөөлдөг юм байна. Энэ нь тэгээд өвчин гарах, өвчин үүсэх үндсийн нэг болдог юм байна. Ийм учраас ийм бодлого баримталж байгаа.

Одоогоор бол отор нүүдлийн хаанаас яаж аль аймаг, аль сумынхан нүүдэл хийх эцсийн хуваарь гараагүй, энэ бас намаржилт, юуны байдалтай ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Идэрбат гишүүн тодруулъя.

**Ц.Идэрбат:** Тийм, энэ отор нүүдэл бол малын өвчний бас нэлээн үндэс болдог. 90 гаруй хувьтай вакцинжуулалт хийсэн байна л гэж байгаа. Тэгээд эндээс вакцинжуулалт хийлгээгүйн улмаас энд тэнд очиж өвчин тараагаад явдаг. Энэ асуудлыг ер нь бас нэг жоохон тийм хариуцлагажуулахгүй бол зүгээр отроор очоод л тэнд нь өвчин тараачхаад л яваад өгдөг. Тэгээд тарьсан ч юм уу, тариагүй ч юм уу нэг худлаа үнэн нь мэдэгдэхгүй нэг тодорхойлолттой явдаг. Энэ их орон нутагт маш их төвөгтэй байдал үүсгэдэг, маш их голомтуудыг шинээр бий болгодог нэг асуудал байгаа юм.

2-т, энэ мал махны экспорттой холбоотой асуудлыг бас нэг жоохон тийм нэг шилэн болгоод, ил болгоод ингэмээр байгаа юм. Амьд махны квотыг жишээ нь хуучин сайд асны эхнэрийн дүү ч билүү ингээд л нэг ийм хардлага яваад л байдаг шүү дээ. Тэгээд энд эд нар нэг тодорхой хариулт өгчихмөөр байгаа байхгүй юу. Монопол байдал үүсгэх гээд ч байгаа юм уу яагаад байгаа юм?

Дээрээс нь энэ ордны баруун талд энэ зунжин, намаржин боллоо, 1 эмэгтэй байгаа. Бас л нэг махны квотын хэрүүлтэй. Тэгээд энэ хүн ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Болорчулуун сайд хариулъя даа. Тодорхой хариулаарай.

**Х.Болорчулуун:** Энэ хоршооны талаар авсан ялангуяа ноолуур аваад энэ ноолуур дээр бол үндэсний ААН-үүд авахаар ингээд НӨАТ төлөгч байдаг. Гэтэл яг гаднын хөрөнгө оруулалт нэртэй хүмүүс мөнгө гаргаж аваад гарахад ямар ч экспортын татвар байхгүй. Энэ нь ингээд эрс тэс байдлыг, 10 хувийн ялгааг бий болгож байгаа юм. Тэгэхээр цаашидаа бас энэ бодлого хууль, тогтоолдоо өөрчлөлт оруулаад зөвхөн НӨАТ төлсөн, татвар төлөгч ААН ноолуур экспортлох энэ тэр байдалаар ингэж оруулж байж энэ ялгаа арилна гэсэн ийм бодомжтой байгаа шүү. Ингэх нь зөв өө гэсэн ийм

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бодолтой байгаа. Бодлоготой байгаа. Тэгээд үүнийг хэрэгжүүлнэ.

2 дугаарт, вакцинжуулалт. Энэ дээр би сайд болоод нэг анхаарсан зүйл бол вакцины мөнгө яаж тавьсан байсан, тэр вакцин малдаа очихгүй .../минут дуусав/

**Б.Саранчимэг:** 1 минут өгье. Болорчулуун сайдад.

**Х.Болорчулуун:** Малдаа очихгүй тэгээд хий тарилга болдог ийм байдал амьдрал дээр яг мэдэгдсэн. Юу гэвэл энэ нэг биш аймгийн мал эмнэлгийн складад вакцин тарианы үлдэгдэл их хэмжээгээр хугацаа хэтэрсэн байдлаар гарсан. Энэ юутай холбоотой, төрөөс үзүүлж байгаа энэ мал эмнэлгийн үйлчилгээний хөлс хэт бага байсан. Үүнийг энэ 24 онд нэмэгдэж оруулахаар шийдвэрлэсэн. Энэ нь цаашидаа вакцин 2 жилийн өмнө нэг нэмсэн юм, одоо дахиж нэмж байгаа нэмэхээр болсон. Энэ нь хувийн мал эмнэлэг чадавхжих, вакцин болгон, тарилга болгон малдаа очих ийм үндэслэл болно оо гэдгийг бас хэлэх байна.

Тэр лоозонгийн талаар энэ эмэгтэйтэй 2 удаа уулзсан, ажлын хэсэг гарсан, өөрөө үйлдвэргүй юм байна лээ. Урьд нь урьд урьдын сайдууд намайг ингэж хохироосон гэсэн ийм асуудал яадаг. Тэгэхдээ боломжгүй шаардлага тавьдаг, хууль бус шаардлага тавь ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр МАА-н өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах ажлын, ургац хураалтын ажлын мэдээлэл сонсож байна л даа. Тэгэхээр энэ жилийн хүйтний улирлын төлөв ер нь ямархуу байна гэж гарав аа? Энэ дээр ер нь тодорхой тайлбар мэдээлэл байна уу гэж.

2 дугаарт, ерөөсөө МАА өвөлжилтийн бэлтгэлийг хангая гэхээр бид нар энэ өвс тэжээлийн бэлтгэлийн л асуудал байгаад байгаа л даа. Тэгэхээр хадлан бэлтгэх бүс нутаг харьцангуй бага байгаад байдаг. Энд бэлтгэгдсэн өвс тэжээлийг яаж тэр гантай гэдэг юм уу, өвөлжилт хүндрэх бүс нутгууд руугаа аваачиж байриуулах вэ л гэдэг асуудал бидэнд хамгийн гол зүйл л байгаа. Энэ дээр төрийн бодлого дэмжлэгийн асуудал гэж байна уу гэдэг нэг ийм зүйл байна.

Дараагийн нэг зүйл. Улсын хэмжээний тэр нөөц бүрдүүлэлтийн ажил ер нь ямархуу шатдаа яваад байгаа юм бэ? Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлт. Аймгууд, сумд нэг аюулгүй нөөцдөө нэг жоохон жоохон ногоон тэжээл өвс бэлдэж байгаа. Олон найрлагад гэдэг юм уу тэр илчлэг тэжээлүүдийн асуудлыг улсын нөөцөөр бүрдүүлэлт хийгээд яваад байгаа. Үүний бүрдүүлэлт, үйлдвэрлэл ер нь ямархуу түвшинд явж байна вэ гэдэг асуудал.

3 дахь гол анхаарал татагдах ёстой зүйл бол энэ малаа ангилж, мах бэлтгэлийн ажлыг нэмэгдүүлэх тухай л асуудал бидэнд байгаад байгаа л даа. Тэгэхээр зэрэг би бодоод байгаа юм. Энэ эр сувай гэдэг юм уу, өсвөр насныхаа малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар ер нь яам бодлогын түвшинд юу бодож барьж ажиллаад байна вэ. Энэ булангийн орнууд руу хэдий хэмжээний өсвөр малын мах гарах тийм гэрээ хэлцэл юмнууд байгаад байна вэ гэдэг асуудал байна. Энэ дээр 2 зүйлийг хооронд нь уялдуулж бодох шаардлага байгаа юм уу гэж бодоод байдаг. Экспортын махны үнийн доод түвшин, дотоодын нөөцийн махны үнийн дээд түвшин 2-ыг бид хооронд нь зохицуулж, энэ мах бэлтгэж байгаа аж ахуйнуудтайгаа гэрээ хэлцлийг зөв хийхгүй бол хэрэглээ талдаа үнэ өссөн гэдэг шүүмжлэл гараад л, экспорт талдаа ер нь дотоодын хэрэглээнээсээ бараг хямд шахуу үнэтэй мах гадагшаа гараад ч байгаа юм шиг. Ингээд ийм нэг сонин дүр зураг л харагдаад болчихгүй



2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа. Энэ дээр ер нь ямар дүн шинжилгээ хийж яаж зохицуулж байна вэ гэдэг асуудал.

Дараагийн нэг асуудал. Мал эрүүлжүүлэлтийн ажил дээр бид онцгой анхаарал хандуулж байгаа. 2023 онд мал эрүүлжүүлэлтийн ажлын төсвийг 3 дахин нэмэгдүүлсэн. Хуучин 20 орчим тэрбумаар явдаг байсан юмыг 41 тэрбумаар нэмэгдүүлээд энэ чинь бараг 61 тэрбум ч билүү болгосон. Тэгээд энэ ажлын үр дүн, үр нөлөө ер нь ямар байна вэ? Тэгээд та хэдийн оруулж ирсэн мэдээлэл юмнуудыг харахаар зэрэг зарим нь 90 хэдэн хувьтай, зарим нь наяд хувьтай энэ тэр байх юм. Яагаад хамрагдах ёсны малын тоо толгой бүрэн хамрагдаж болохгүй, тухайн бүс нутагт байгаа мал хамрагдахгүй байна вэ? Энэ чинь өөрөө дахиад энэ төрлийн өвчний голомтыг үүсгэх нөхцөлийг л бүрдүүлнэ шүү дээ. Тэгэхээр энэ нөхөдтэй ер нь яаж хариуцлага юмнууд яриад байгаа юм бэ? Хэдийгээр хувийн өмчид бид юу хийж байгаа ч гэлээ гэсэн амьд амьтан учраас энэ өөрөө энэ халдварт өвчний голомт тээвэрлэлтийн асуудал болоод байдаг. Тэгэхээр үүн дээр ер нь бид ямар зохицуулалт хийх шаардлага юм байна гэж хараад байна уу гэж.

Ургац хураалтын ажил дээр хэд хэдэн зүйл байна. Одоо яг хэдэн хувьтай байна вэ? Ургац хураалтын ажил. Цэрэг оюутнууд буцаад татагдаж байна. Яг нарийндаа. Байгаль, цаг уур сая ерөөсөө үндсэндээ нэг 3 хоноод л нэг хонууд бороотой, 3 хоноод л нэг хонууд бороотой. Үндсэндээ газар тариалангийн энэ ургац хураалтын ажил чинь нэг бараг 20 гаруй хоног зогсчихлоо шүү дээ. Тэгээд яг ажил эрчимжээд явах гэхээр зэрэг ажиллах хүчний дутагдал үүсэх нь ээ. Үүнийг хэдүүлээ яаж зохицуулах вэ? Дан дамаа малын ногоон тэжээл хураалтын ажил үндсэндээ цэвэр ажиллах хүчин дээр явагддаг ийм зүйл. Ногоон тэжээл /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Тэгэхээр Батжаргал гишүүний асуултад хариулъя. Болорчулуун сайдын микрофоныг өгье.

**Х.Болорчулуун:** Өвөлжилтийн бэлтгэл гэдэг бас Батжаргал гишүүний хэлдгээр өвс тэжээлээ бас хангалттай нөөцлөх ёстой. Түүнээс гадна малчид орлоготой байх ёстой л доо. Тийм ч учраас харин энэ жил харин махны орлого малчдын хувьд сайн байгаа. Өнгөрсөн жил одоогийн байдлаар үгүй ээ, өнгөрсөн жилийн хугацаанд 22 онд нийтдээ 16 мянган тонн мах экспортод нийт гарсан одоогийн байдлаар 8 сарын дүнгээр 46 мянган тонн малын мах экспортод гараад байгаа.

Өвс тэжээлийн хөнгөлөлт гэж байхгүй ээ. Энэ зах зээлийн жамаар явна. Энэ дээр яамнаас ямар нэг хөнгөлөлт гэсэн асуудал байхгүй. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх асуудал Шадар сайдын ажил, хамаарлын асуудал, одоо яг хэдэн хувьтай байгаа нь Шадар сайдын ажлын алба тодорхой тоо мэдээлэл өгөх байх аа гэж бодож байна.

Мал махыг экспортод гарахад нэг сувгаар нэг улс руу гаргахад бас манайхан бас худалдааны соёл юунаас ч болдог юм уу, ер нь нэг нэгийнхээ үнийг унагах байдал гарч байсан. Тийм учраас бас мал мах экспортод гарах доод үнийг гэж махны холбоотойгоо, яам биржтэй ингэж бодлогын хувьд гаргасан. Жишээ нь доод үнэ хонины мах 3,5 доллар гэж байх жишээтэй. Хэрвээ энэ доод үнээс доогуур гэрээ хэлцэл хийж ингэж гаргавал тэр экспортлогч компанитай бодлогын гэрээ энэ тэр хийхгүй ээ гэсэн асуудлыг хүртэл гэрээн дээрээ яригдсан байгаа гэдгийг бас хэлье.

Ургац хураалтын байдал энэ жил уг нь сүүлийн 10 жилд байхгүй га-гийн ургац өндөр байсан юм. Гэтэл сүүлийн 10 жилд байхгүй намрын бас нэг хатуу намар болж байна. Тариаланчдын хувьд бол. Дөнгөж 9 хувьтай. Уг нь өдийд бол 50, 60 хувьд хүрчихсэн байх, жилийн

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

жилдээ хүрдэг. Тэгэхээр ургац хураалт даруй хагас сараар хоцорч байна гэсэн үг. Үүнтэй холбогдуулан 3 хоногийн өмнө Засгийн газраар манай яам тогтоол гаргуулсан байгаа. Үүгээрээ энэ бүх их, дээд сургуулийг 14-21 хоног цаашаа сунгах оюутан сурагчдыг ийм чиглэлийг өгсөн байгаа. Бүх их, дээд сургуулиуд.

Өчигдөрхөн, уржигдархан гээд Төв аймгийн Хөдөө аж ахуйн газрын дарга надтай ярьсан. Ингээд юуныхан бас цэрэг энэ батлангийнхан, батлан хамгаалах яамныхан цэргүүд энэ 10 сарын 15-нд халагдах юм байна. Тийм учраас ингээд цэргээ татчих гээд байна аа, үүнийг хойшлуулж өгөөч ээ гэсэн. Энэ асуудлыг батлан хамгаалах сайдаар нь дамжуулаад хэлсэн. Ингээд 10-д гартал цэргүүдийг ажиллуулах талаар асуудал шийдэгдсэн байгаа гэдгийг бас хэлье.

**Б.Саранчимэг:** Мал эрүүлжүүлэхийн тал дээр бас салбарынхнаас нэмж хариулъя. 1 номерын микрофоныг өгье.

**Г.Наранчулуун:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн хүйтний улирлын төлөв баруун талаасаа говь руугаа чиглэсэн нутгаар нэлээд их олон жилийн дунджаас хүйтэн байна гэсэн цаг агаарын төлөв гарсан. Төвийн нутгаараа цаг агаарын температур болон хур тунадасны хэмжээ хэвийн олон жилийн дунджаар орчим байна. Харин зүүн талдаа хур тунадас ахиу байна гэсэн ийм төлөв гарсан байгаа.

Вакцинжуулалт яагаад дутуу яваад байгаа юм бэ гэсэн асуултад гарч байгаа. Тэгэхээр бод дээр ялангуяа нэлээн дутуу явдаг байсанд дүгнэлт хийж, 24 оны төсөвт бод малын үзлэг, ангилалт, вакцинжуулалтын автомат хашааг бүх сумд нийлүүлэхээр зарим юунд үхэр ихтэй сумд 2-ыг ч юм уу ингэж нийлүүлэхээр 400 автомат хашааны төсвийг тусгасан байгаа. Ингэснээр бид нарын ажил 1 дүгээрт хөнгөвчлөгдөнө. Мал баригч гэдэг хүн тэр чадалтай үхэртэй ноцолддог

хүнгүй болсон. Үүнтэй бас нэг холбоотой нэг ийм дутуу асуудлууд гарч байгаа юм.

2 дугаарт нь, бог дээр яагаад дутуу яваад байна гэхээр бид нар мялзангийн энэ жил мялзангийнхаа вакциныг төлүүддээ хийхээр төлөвлөсөн. Өнгөрсөн жил гэхэд 24 сая төл хүлээж авсан, энэ жил нэг 22-оос доошгүй гэж бодож төлөвлөсөн боловч 18 сая төл хүлээж авсан. Тэгэхээр төлөвлөлт хүрэхгүй байгаа шалтгаан нь энэ тоон дээр явж байгаа юм.

**Б.Саранчимэг:** Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тийм, дараагийн нэг зүйл энэ газар тариалангийн салбарыг дэмжээд бид нар зээлийн багцууд гаргасан. Зээлийн ашиглалт ер нь ямар байна аа? Энэ яваад байгаа банкны системээр дамжуулж байгаа энэ үйл явц ер нь үйлдвэрлэлийнхээ өргөтгөл, өнөө хүнсний хангамжаа бий болгоход ер нь хэр онож байна вэ? Үүн дээр нэг тайлбар өгөөч. Би бол нэг 300 хэдэн тэрбум төгрөг Хөдөө аж ахуйн салбар дээр тавигдсан. Одоо нэг 170-ын ашиглалттай байгаа юм уу гэмээр л ийм л юм яригдаад байна шүү дээ.

Энэ стратегийн болон технологийн нөөц бүрдүүлэлт дээр бид 30 хэдэн тэрбум төгрөг тавьчихсан. Тэгээд энэ мөнгийг зүгээр намар ургац авч нөөц бүрдүүлэх хэлбэрээр ашигламгүй л байгаад байгаа юм. Яг үнэнийг хэлэхэд. Ерөөсөө энэ салбарын өөрийнх нь үйлдвэрлэлийг зөв удирдахад хавраас эхэлж ашигламаар санагдаад болж өгөхгүй байгаа юм. Үүн дээр ер нь ямар бодлого зохицуулалт хийе гэсэн ийм бодлого чиглэлүүд байна уу гэдэг асуудал байна.

Дараагийн нэг зүйл. Урамшууллын асуудал ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Батжаргал гишүүнд 1 минутыг өгье, нэмж.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Ж.Батжаргал:** Урамишууллын асуудал байгаад байгаа юм. Сая би ер нь газар тариалангийн бүсээрээ бүтэн явсан. Хүнсний ногоонд бид урамишуулал өгөөд байгаа. Гэтэл өнөө жинхэнэ үнэ цэн бүх юмаа нэмэгдүүлж гаргадаг хүлэмжийн аж ахуй дээр ижил түвшин барьчхаад байгаа нь үйлдвэрлэлээ дэмжих бодлого болж чадахгүй байгаа юм билээ. Талбайд тарьдаг масс ургац өгдөг ногоо болж байна. Одоо га-аас 200 хэдэн центнер энэ тэр авчихдаг юун дээр тонн тутамд 100000-ыг өгч болж байна.

Хүлэмжийн аж ахуй дээр тонн тутамд 100 мянга өгнө гэхээр зэрэг бүхэл бүтэн нэг жил ноцолдоод 5 тонн помидор гэдэг юм уу, 5 тонн огурцы авдаг газар дээр чинь 500 мянган төгрөгийн л урамишуулал болчихоод байгаа байхгүй юу, энэ чинь. Тэгэхээр үүнийгээ ер нь бид яаж шуу зөв зохицуулах вэ гэдэг асуудал байна аа гэж.

Дараачийнх нь, механикжуулалтын асуудал байгаад байгаа. Яам бүхэл бүтэн бодлогын газартай. Энэ улсууд явж Монголын энэ төмс хүнсний ногооны салбарт аль орны ямар хүчин чадалтай, ямар бүтээмжтэй техник ... /минут дуусах/

**Б.Саранчимэг:** Хэн хариулах вэ? 1 номерын микрофон. Сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай 36 дугаар тогтоолын дагуу энэ хүнс үйлдвэрлэгч, газар тариалан эрхлэх ААН-үүдэд хөнгөлөлттэй зээл буюу жилийн 6 хувийн хүүтэй зээл олгож байгаа. Энэ нь үнэхээр байндаа тусаж, тариаланчид маань бас энэ дээр баяртай байгаа. Нийтдээ тариаланчид 180-аад тэрбум төгрөгийн зээл аваад байна. Хөнгөлөлттэй зээл. Бас хөнгөлөлттэй зээлийг өшөө улам өргөтгөх үүднээс хүрээгээ нэмэгдүүлэх үүднээс хуучин бол урд авсан зээлийг нөхөн төлүүлэхгүй гэсэн байдалд журам гарсан байсан. Үүнийг урд авсан зээлийнх нь 50 хувийг нөхөн төлүүлэхээр ингээд

журамд 10 хоногийн өмнө Сангийн яам, Монголбанк энэ арилжааны банкнуудтай ингээж ... /минут дуусах/

**Б.Саранчимэг:** Цаанаасаа энэ юуг нь өгөөд байгаа юм. Микрофон 4 минутаар өгөгдөж байгаа юм. Бейсен гишүүн асуултаа асууя.

**Б.Бейсен:** Энэ Засгийн газрын 23 оны 279 дүгээр тогтоолоор аймаг, нийслэлийн аюулгүй байдлын нөөц бүрдүүлэх зөөх өвс тэжээлийн хэмжээг хүргүүлсэн байгаа. Энэ дээр ийм юм байна л даа. 21,5 мянган тонн өвс, 12,6 мянган тонн тэжээл бэлдэхээс одоогийн байдлаар гэж байна, 2105 тонн өвс, 425 тонн тэжээл бэлтгээд байгаа юм байна л даа. Өвс тэжээлийг нь зөвхөн 10 хувь, тэжээлийг нь нэг 30 хувь бэлдсэн байна л даа. Гэтэл аймгууд дээр тендер зарлах гэрээ байгуулах шатандаа явж байна гэж. Энэ нь бас жаахан оройтоод байна л даа. Энэ хэзээ дуусах вэ. Ер нь аймгуудыг шаардах уу гэдэг жосоохон газар аймгуудыг шаардахгүй бол үнэд орсон хойно нь тендер зарладаг. Одоогоор өвсний буусан үед нь зарлах уу, үүнийг аймгуудаа шаардаж байгаа юу, 1 дүгээрт.

2 дугаарт, энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэсний хөдөлгөөн явагдаж байгаа л даа. Ер нь дотоодод тариалсан хүнсний ногоо хэдэн хувийг нь хангах вэ? Одоогийн байдлаар тооцоо байна уу? Нөгөө хуваарилсан хэдэн тэрбум төгрөг хуваарилсан юм. Тэрийг аль, аль аймагт хэдийг хуваарилсан. Дотоодод хангах боломж юу байна? Гадаадад хэчнээн тонноор хүнсний ногоо импортлох вэ? Гадаадын хүнс чинь ихэнх нь зарим нь гений өөрчлөлттэй, зарим нь тийм эрүүл ахуйн шаардлага хангахгүй асуудал ярьж байгаа шүү дээ. Энэ тал дээр тодорхой гаргасан шийдвэр байна уу? Яг тоо, хэмжээгээ хэлж өгөөч?

**Б.Саранчимэг:** Болорчулуун сайдын микрофоныг өгье.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Х.Болорчулуун:** Бейсен гишүүний асуултад хариулъя. Бейсен гишүүн бас нэг Баян-Өлгий аймагт цаг агаар хүндрэлтэй болж болзошгүй байдал үүсээд байна гэж санаа зовж асууж байна. Ялангуяа улсын нөөц, өвс тэжээлийн талаар. Энэ улсын нөөцийн аюулгүйн нөөц бүрдүүлэх энэ төсөв Шадар сайдын багцад байгаа. Тэгэхээр яг нарийн тоог Шадар сайдын ажлын алба гаргана. Ер нь тэгээд өвөлжилттэй холбоотой бас Шадар сайдын бас нэг ажлын алба, Шадар сайдыг ер нь Байнгын хороогоор тэгж байгаад нэг дараа дараачийн хуралд л оруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Энэ дотоодоос хүнсний ногоо хэдэн тонныг авсан бэ гэсэн асуултыг асуулаа. Энэ жил 23 онд анх удаа Монгол Улс бас түүхэндээ 165 мянган тонн хүнсний ногоо хураан авах ийм урьдчилсан баланс гарсан. Үүнийгээ хурааж авна. Хүнсний ногоон дээр бол. Энэ Монгол Улс түүхэндээ хамгийн өндөр ургац хурааж авах ийм боломж бүрдэж байна гэсэн үг. Дотоодын хэрэгцээгээ 82 хувиар хангах ийм урьдчилсан баланс гарсан. Тийм учраас бид нар гаднаас аваад байх нэг их онцын шаардлага байхгүй. Иймээс Засгийн газраар оруулаад энэ хүнсний ногооны импортын татварыг бас нэмэгдүүлэх асуудлыг ХХААХҮЯ-аас бүх 30 хүртэл хувиар нэмэгдүүлэхээр бүх яамдаас санал аваад ингээд Засгийн газрын хурлаар ер нь дараачийн хурлаар орчих байх. Тэгээд бүр үүнийг зөвхөн Засгийн газрын тогтоол биш Их Хурлаар оруулж баталгаажуулахгүй бол нэг Засгийн газар гарч ирэнгүүтээ татвараар хөдөлгөөд байх вий гэсэн байдлаар ингээд Их Хурлаар оруулна гэсэн ийм бодлоготой ажиллаж байгаа. Хүнсний ногоо бол дотоодоос хангалттай авах хэмжээнд байгаа шүү. Ирэх жил гэхэд 90-100 хувь хүнсний ногоо хангагдана аа гэдгийг бас хэлэх байна.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Гол яах вэ сая хөдөө орон нутгуудаар яваад ингээд ярихаар гол хүндрэлтэй асуудал яах вэ, мал махны үнийн асуудал байгаад байгаа. Тэгээд бид нар цаашидаа нөгөө мал, махныхаа үнийг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах дээр анхаарах дээр гол асуудал ерөөсөө малын эрүүл мэндийн асуудал. Тэгэхээр ерөөсөө малынхаа махныхаа үнийг тогтвортой барих, малын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүнийхээ үнийг бас тогтвортой байлгах, цаашид экспортоо нэмэгдүүлэх бодлогын хүрээнд малынхаа эрүүл мэнд дээр бас нэг тодорхой хариуцлагатай байх, энэ дээр анхаарахаас өөр зайлшгүй шаардлагатай л байгаад байгаа юм.

Тэгэхээр би энэ дээр яах вэ, Улсын Их Хурлаас бид нар өнгөрсөн онд нөгөө нэг малын гоц халдварт өвчинтэй тэмцэхтэй холбогдуулж урьдчилан сэргийлэх чиглэлээр дархлаажуулалтын ажилд тодорхой дэмжлэгүүдийг үзүүлсэн. Гааль, НӨАТ-аас чөлөөлөх зардлуудыг бас гаргасан. Дээрээс нь үйлчилгээний хөлснүүдийг нь бас төрөөс бас тодорхой шийдэж өгсөн. Вакцин тунгийн асуудлыг шийдсэн. Гэтэл одоо яах вэ, бодитой амьдрал дээр очихоор яг хангалттай вакцин, дархлаажуулалтын эм тариа ирэхгүй байгаад байгаа асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр асуудал нь та хэд бас хаанаа байгаад байна. Энэ дээр бас нэг анхаараач ээ. Би яах вэ зүгээр дотрын хордлого гээд л аваад үзэхээр 5 сардаа бид нар хийх ёстой болчихоод байдаг, ногоо гарахаар хийх ёстой болчихоод байдаг, цаг хугацаандаа амждаггүй, төлөвлөгөөт ажилдаа амждаггүй, тэгээд сарын дараа ирдэг ч гэдэг юм уу. Эсвэл богийн мялзангийн асуудлууд гээд сая гардаг. Сая яг хөдөө орон нутгаар яваад үзэхээр Архангай дээр жишээ нь манай аймаг дээр Цэцэрлэг сум дээр Хонгор багаас гарч байсан. Тэгтэл сүүлд нь 2, 3 сарын дараа, 4, 5 сарын дараа вакцин тариа дээр ирж байгаа юм. Вакцин тариа нь ирэхээрээ бас хангалттай хэмжээгээр ирдэггүй, тэгээд зөвхөн юу гэдэг юм бог

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

малаас гээд аваад үзэхээр ямаан дээрээ хийдэг, хурга шигэн дээрээ хийдэг, хонио орхиод явчихдаг асуудал гарч ирж байгаа юм. Гол асуудал юу вэ гэхээр ерөөсөө л үндсэн хангалттай хэмжээний вакцин тариа туулга ирэхгүй байна аа л гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар ер нь Био комбинат дээрээ анхаарах ёстой юм биш үү? Асуудал нь хаанаа байгаад байна аа? Био комбинатын нөгөө өргөтгөлийн асуудлууд юу болсон бэ? Унгарын Засгийн газрын зээлээр энэ уг нь хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, дотооддоо ядаж хангалттай хэмжээний вакцин тариагаа үйлдвэрлэдэг болох асуудлыг шийдэх чиглэлийг уг нь Улсын Их Хурлаас өгсөн. Тэгэхээр ерөөсөө ингэж байж л цаашидаа нэг энэ урьдчилан сэргийлэх био бэлдмэл, тэр дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангадаг болох л нөхцөлд очих гээд байдаг. Та хэд маань ер нь энэ дээрээ ямар ажлыг хийгээд байна вэ? Төр засгаас бид нар ер нь юун дээр анхаарах ёстой болчихоод байна вэ? Одоо нэг ядаж ойр зуурынхаа хэрэгцээнийхээ хэмжээний био бэлдмэл, вакцин тариагаа дотооддоо үйлдвэрлэх хэмжээнд очихгүй бол байнгын л гаднаас Оросоос гээд яриад байдаг гадагшаа гээд яриад байдаг, хугацаандаа орж ирдэггүй. Энэ дээр нэг жосоохон дүгнэлт хийхгүй бол ер нь хүндрэлтэй байгаа юм биш үү? Богийн мялзан дээр та хэдийн мэдээллээс аваад үзэхээр дархлаажуулалтын ажилд 18,9 сая бог мал хамруулахаас 17,6 сая бог мал хамруулсан гээд байгаа. 92,8 хувийн гүйцэтгэлтэй гээд байгаа. Үлдсэн 8 хувь нь юун дээр хийгдээгүй үлдсэн юм бол? Яг зүгээр нэг аймгийн жишигээр аваад үзэхээр магадгүй нэг 60, 70 хувь нь вакцинд хамрагдаад үлдсэн 20, 30 хувь нь хамрагдахгүй болчихоод байдаг. Дотрын хордлого дээр үндсэндээ 40-45 хувийнх нь тариа нь дархлаажуулалтынх нь ажил нь хийгдээд байдаг. Үлдсэн 50, 60 хувь нь хийгдэхгүй болчихоод байдаг. Энэ дээр та бүхэн нэг манай яамны газрын дарга нар мэргэжлийн хүмүүс та бүхэн мэдээлэл өгөөч ээ.

Тэгэхээр бид нар энэ дээр онцгой анхаарч байж л цаашидаа нэг малынхаа эрүүл мэндийг сайжруулж байж л мал махаа экспортлох, түүхий эдийнхээ үнийг тогтвортой байлгах, хүнснийхээ аюулгүй байдлыг хангах энэ боломж бололцоо л бүрдэх л нөхцөл бүрдэх гээд байгаа юм. Уг нь төрөөс бид нар бас боломжийн хэмжээнд хөрөнгө мөнгийг нь шийдээд байна гэж хараад байгаа. Хариуцлага нь хаанаа байгаад байна вэ, асуудал нь хаанаа байгаад байна вэ? Бид нар цаашидаа хамтарч юун дээр анхаарах вэ? Энэ дээр нэг тодорхой нэг та бүхэн мэдээлэл тайлбар өгөөч ээ л гэж хэлэх гэсэн юм.

**Б.Саранчимэг:** Тэмүүлэн гишүүн маш чухал асуудлыг хөндөж байна. Малын эрүүл мэндтэй вакцин бас зайлшгүй салшгүй холбоотой байгаа. Тэгээд энэ дээр маш тодорхой асуултууд асуулаа. Болорчулуун сайд эхлээд хариулъя. Газраас хариулъя эхлээд. 1 номерын микрофоныг өгье.

**Г.Наранчулуун:** Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Халдварт өвчин маань гоц халдварт, халдварт гэсэн 2 ангилалтай явж байна. Гоц халдварт өвчин нь болохоор улсын төсвөөс санхүүжигдэж байна. Дотрын халдвар, хордлогот халдвар, халдварт хордлого гэх мэт энэ халдварт өвчнүүд нь орон нутгийн төсвөөс санхүүжигдэж байгаа юм. Тэгэхээр энэ орон нутаг өөрсдөө захиалгаа өгөхдөө оны эхэнд захиалгаа өгсөн хэмжээгээр нь Био комбинатад халдварт өвчнийхийг үйлдвэрлэж байна. Гоц халдвартаас зөвхөн цэцгийн вакциныг Био комбинатад үйлдвэрлэж байна. Мялзан болон шүлхийн вакциныг гаднаас авч байгаа.

**Б.Саранчимэг:** Сайд нэмж хариулъя.

**Х.Болорчулуун:** Гишүүн мал махныхаа үнийг нэмэгдүүлэхийн тулд малаа эрүүл болгох талаар юм ярилаа шүү дээ. Тийм. Одоо бид нар экспорт нь

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэдийгээр мах боломжийн экспортод гарч байгаа боловч үнэ нь энэ лангуун дээр зарж байгаа үнээс хямдаар гаргаж байгаа. Энэ бол малаа бүрэн эрүүл гэдгийг баталгаажуулж чадаагүйтэй холбоотой. Хэрвээ бид нар олон улсын жишигийн дагуу тусгаарлагдсан аж ахуй, хамгаалагдсан аж ахуй байгуулаад эрүүл бүс байгуулаад мал махаа гаргавал үнэ нугарч нэмэгдэнэ. Бид тэр ажлыг хийх ажлаа эхлүүлчихсэн байгаа. Энэ намрын чуулганаар Хөдөө аж ахуйн бүсийн хууль орно. Мөн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль дээр нэмэлт тодотгол оруулахаар ийм ажиллаж байгаа.

Юу, вакцин дээр яг Тэмүүлэн гишүүний хэлдгээр үйлчилгээний хөлс бага байсны улмаас малдаа хүрэхгүй ийм явдал ажиглагдсан. Тийм учраас 24 оны төсөв дээр бүр нэлээн юм болж байж Сангийн яаманд үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлж байгаа шүү гэдгийг. Тэгэхээр нь ялангуяа тэгээд энэ тарилгын хөлсийг маш уялдаатай сумдын малчидтай нь холбосон ийм нэг хяналтын систем гэж нэвтрүүлэх хэрэгтэй юм байна гэж. Малын эмч тарьсан тариагаа бүгдийг нь хянах ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Тэмүүлэн гишүүн тодруулъя.

**Г.Тэмүүлэн:** Асуудал байна. Би зүгээр шийдэл хайгаад байгаа юм. Тэгэхдээ та бүхэн чинь нөгөө Био комбинат чинь яг үнэндээ асуудал үүсгээд байна шүү дээ гээд хэлэхээр үгүй ээ, бид нар та бүхний орон нутгаас чинь захиалсны чинь дагуу нийлүүлээд байгаа гээд хариулт өгөөд байх юм. Би зүгээр бодитой жишээ хэлэхэд 5 сарын 15-нд өгөх ёстой байсан чинь дотрын хорт халдвар жишээ болгож л хэлж байгаа юм шүү. 1 саяын малыг Архангай аймаг чинь би зүгээр дотрын орлогын дархлаажуулалтад хамруулах ёстой гээд төлөвлөгөөгөө бид нар захиалгаа өгөнгүүт буцаагаад өгч байгаа нь бүр 5 сарын 30 гэхэд дөчин наймхан хувийнх нь дотрын орлогын вакцинжуулалтын

дархлаажуулалтын тэр эм тариаг л өгч байгаа, вакциныг өгч байгаа юм. Тэгэхээр ерөөсөө бодит байдал дээр нөхцөл чинь ийм болчихоод байна. Цаг хугацаа нь хоцорч байна, ирүүлж байгаа вакцин тун нь өөрөө багаар ирж байна гэдэг асуудал байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө энэ Био комбинатаа нэг шинэчлэх дээр үүнийгээ нэг асуудлыг нь шийдэх тал дээр нэг анхаараач. Хөрөнгө мөнгө шийдэх ёстой юм бол бид нар ганц энэ асуудал дээр ядаж хөрөнгө мөнгийг нь гаргаад шийдэх юм руу орохгүй бол хэдий байтлаа ингээд нэг 10, 15 жил, 20 жил ингээд л Био комбинатаа харсаар байгаад дуусах юм байна л гэдэг асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр шийдэл гаргая л гэдэг асуудал байна шүү дээ.

**Б.Саранчимэг:** 1 номерын микрофоныг өгье. Яг ямар шийдэлтэй байгаа юм? Энэ тал дээр.

**Г.Наранчулуун:** Био комбинатын хүчин чадалд бас тохируулж ажиллаж байгаа нь үнэн. Тийм учраас энэ Дэлхийн банкны ирэх 100 сая ам.долларын төслийн 20 сая ам.доллароор нь Био комбинатыг шинэчлэх төслийн бичиг баримтууд тусгачихсан явж байгаа. Үүгээр энэ Био Комбинатыг үнэхээр шинэчлэхгүй бол 75 оны барилгатай, яг био аюулгүй байдлаа аргагүй эрхэнд л барьж явж байгаа ийм нөхцөл байдалтай байгаа. Тэр бол үнэн.

Тэгээд хүчин чадалд нь бас тааруулж вакциныг үйлдвэрлэж байгаа. Түүнийх нь хэмжээгээр хуваарилалт хийж байгаа.

**Б.Саранчимэг:** Ганболд гишүүн асуултаа асууя.

**Г.Ганболд:** Яах вэ, өвөлжилтийн бэлтгэл ярьж байна л даа. Одоо ярьдаг цаг, зөв. Өвөлжилт ямархуу байх нь тодорхой болж байна. Баруун аймгуудын зарим аймгуудаар одоо хүндрээд эхэлж байна гэж ярьж байна шүү дээ. Гэтэл Хөдөө аж ахуйн сайд бол өвс тэжээлийн

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нөөцийн асуудал энэ Шадар сайдын асуудал байгаа, бид нар мэдэхгүй гэж сууж ерөөсөө болохгүй шүү дээ. Засгийн газар дээр юу ярьж байгаа юм. Энэ жил та нар Засгийн газарт яаж танилцуулж байгаа юм, энэ өвлийн нөхцөл байдлыг, урьдчилж. Ямар хэмжээний өвс тэжээлийн нөөц бэлдэх ёстой юм гэдэг. Шадар сайдын энэ улсын нөөц чинь өвс бэлдэхээ больсныг мэдэж байгаа юу, яамныхан, удаж байгаа шүү дээ. Өвс огт бэлдэхээ больсон шүү дээ. Ерөөсөө байхгүй, тэжээл жоохон юм бэлдэж байгаа.

Тэгэхээр ер нь цаашидаа ерөөсөө энэ МАА-н салбарын өвөлжилтийн энэ нөөцийн асуудал Шадар сайд руу, УОК-т нөгөө юу, тэнд биш, энэ ХААЯ өөрөө энэ хажуудаа корпорац байгуулсан. Яг энэ гэх корпорацынхаа бүтцэд оруулаад энэ өвс тэжээлийнх нь нөөцийг өөр дээрээ авч явах нь оновчтой юм байна. Тэгэхгүй бол нэгэн рүүгээ заагаад ингээд яваад байх юм үр дүн алга. Тэртээ тэргүйгээр танайх өөрөө корпорац байгуулчихсан. Тэднийх чинь өөрөө жилд ингээд зөвхөн хүнсний улаан буудай гэхэд нэг 45, 55 мянгыг, үрийн улаан буудай гэхэд 10 мянгыг ингээд 65 мянган тонн үр нөөцлөөд явж байна шүү дээ. Тэрэнтэй адилхан танайх ингээд одоо бол гадуур энэ жил ногоон тэжээл тариалсан ААН зөндөө байна. Авах газар олдохгүй, авах хүн байна уу гээд л ингээд явж байна шүү дээ. Тэгээд ингэж байгаад нөөцлөхгүй ингээд улс ядаж корпорацын зохион байгуулалтад аваад энэ тариаланчдынхаа өвсийг тодорхой хэмжээнд хадгалах газраа нөөцлөөд, тэрийгээ борлуулалтад хийгээд эргэлтэд оруулаад буцаад мөнгийг нь өгөөд явах ийм бүрэн боломжууд байгаа байхгүй юу. Тэгээд энэ юм руу явуулахгүй бол ингээд Онцгой комиссыг, Шадар сайдыг хараад сууж байх юм бол сүүлд нь дайрахаараа танай яам руу л дайрна шүү дээ. Одоо хавар өвөлжилт хүндрээд хавар хүндэрлээ гэхэд танайх руу л өвс тэжээл нэхнэ. Шадар сайд яах вэ дээ, нэг журам нь ийм юм хийгээд сууж байна шүү дээ. Тэгээд энэ чиглэлээр бас танай яам

өөрсдөө энэ Засгийн газар дээрээ өвөлжилтийнхөө нөхцөл байдлыг жаахан тодорхой ойлгуулж, энэ өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх тал дээр журамд нь жаахан өөрчлөлт оруулж энэ өвөлжилт хүндрэх гэж байгаа бол хойтон хавар сонгуулийн жил, аягүй бол бөөн улс төржилт болж мэднэ. Жоохон өвс тэжээлийн нөөц бэлдэж байх зайлиггүй шаардлагатай байгаа юм.

Тэгээд квотын тухай яриад байх юм. Би бас энэ махны экспортын асуудлаар явж байсан. Би үхрийн махнаас өөр квот гэж байхгүй л гэж ойлгоод байх юм. Нөгөө чанасан махан дээр чинь квот байхгүй, адууны махан дээр би квот байхгүй гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд маргаашийн тэр Хүнсний аюулгүй байдлын зөвлөлийн хурлаар юуны квот орох гээд байна гэж ойлгов уу? Ойлгов уу? Тэрийг нэг дахиж тайлбарлаач.

Тэгээд энэ Хөдөө аж ахуйн сайд болох дээр зэрэг энэ мал амьдаар гаргах дээр нэмж зөвшөөрөл өгөхгүй гээд байх юм. Яагаад тийм бодлого бариад байгаа юм, энэ чинь олон байж байж энэ олон боомтуудаар бас өрсөлдөөн бий болж байж явахгүй бол нэг ганцхан компанид монопол эрх өгчихсөн. Бүгдээрээ л ярьдаг шүү дээ. Улаан сайдын авгайн дүүгийн компани гээд л нэг компани хэдэн жилийн өмнө ганцаараа зөвшөөрөл авчихсан, монополдоод л, тэгээд өөр хэнийг ч оруулдаггүй. Ингээд монополыг нь дэмжээд суугаад байж болохгүй шүү дээ. Өөр хүмүүс хажууд нь очиж өрсөлдмөөр байна шүү дээ. Тэр нэг хэдэн хайс, төмөр хашаа л барьсан. Гаргах юм уу, нэг хэд хоног тусгаарлах тухай л асуудал болохоос тэнд нэг гайхуулаад хөрөнгө оруулаад байх юм юу ч байхгүй шүү дээ. Зөвшөөрлийг нь олгоод өрсөлдүүлээд яв л даа. Батжаргал гишүүний хэлж байгаагаар тэгээд л тэр хил гаргаж байгаа үнэ дээрээ л бид нар доод хязгаарыг нь тавьж байх өндөр үнээр явахгүй бол тэнд ганцаараа монополдоод амьдын жингээр нь гурван мянга таван зуухан төгрөгөөр авч байна шүү дээ.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Амьдын жингээр нь. Тэгээд ингээд үржээд үзэх юм бол наадах чинь ерөөсөө гулууз мах гулуузаар нь ярих юм бол 7 мянгад л авч байгаа юм байна лээ шүү дээ, тийм үү. 7 мянга гаран төгрөгөөр л авч байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь нэг компани ингээд монопол байгаагийн гай тэр байхгүй юу. Түүнээс Хятадын хил рүү даваад хэдээр орж байгаа нь бүү мэд шүү дээ.

**Б.Саранчимэг:** Шууд авчих уу, дараа нь тодруулах юм уу. Ганболд гишүүнд 1 минут нэмж өгье.

**Г.Ганболд:** Тэгэхээр энэ дээр бас нэг сайд жаахан өөр бодлого барьж байж энэ өрсөлдөөнийг жаахан МАА-н салбар дээр жаахан өрсөлдөөнийг бий болгож энэ өвөл тэртээ тэргүй манайх хэвийн хорогдол сая саяараа байгаа шүү дээ. Энэ хэвийн хорогдолд орж байгаа малуудаа амьдаар нь ч болтугай нэг ингээд гаргах энэ өөр бүсүүд дээр баруун, зүүн бүс дээр гэдэг бас чинь зөв байна. Үүнийг жаахан явуулах нь зүйтэй.

Тэгээд Тэмүүлэн гишүүний хэлээд байгаа энэ жил бас хөдөө зөндөө гарчихсан шүү дээ. Ядаж та нар ингээд одооноос ингээд төлөвлөөд энэ Био комбинатаа ингээд л худлаа муу гээд л байх юм. Тэр чинь хүмүүс нь ажиллаад л ингээд вакцинаа хийгээд байгаа шүү дээ. Зүгээр л зохион байгуулалтын юм байгаа байхгүй юу. Дотрын хордлогын вакцин хэзээ хэрэгтэй гэхээр 5 сард л хэрэгтэй шүү дээ. Дөнгөж ногоо гарч байгаа үед л хэрэгтэй. Гэтэл энэ жил 6 сар болж байхад түрүүчээсээ нэг ч гараагүй байсан шүү дээ. Тэгээд ямар ч хэрэггүй болсон үед нь тэрийг аваачиж тариад яах юм. Дотрын хордлого чинь дөнгөж ногоо ургаж эхэлж байгаа үед 5 сард л хэрэгтэй байдаг байхгүй юу. Гэтэл энэ жил 6 сарын 1 гэхэд Тэмүүлэн гишүүн мэдэж байгаа, хөдөө ерөөсөө 1 ч очоогүй байсан шүү дээ. Тэгэхээр хугацаа алдсан ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Тэгэхээр өнөөдөр бид нар энэ өвөлжилтийн бэлтгэлийн

ажил, ургац хураалтын явц гээд мэдээлэл сонсож байгаа нь бид нар ажлыг хурдасгах, цаашидаа бас энэ ажлын нөхцөл байдалтай уялдуулж цаашидаа яаж ажиллах вэ гэдэг дээр л бид нар Байнгын хороо ярьж байгаа шүү дээ. Тэгээд 1 ингээд нэг сонсоод ярьдаг. Дараа нь ямар ч үр дүнгүй, иймэрхүү байж болохгүй шүү.

Тэгээд гишүүд маш тодорхой саналууд хэлж байна. Өнөөдрийн энэ саналуудыг эргээд протоколоор яг бас үүрэг даалгавар болгоод эргүүлээд яг ямар ажил хийгдэж байгаа талаар бас манай салбарын яам, Байнгын хороонд ирүүлээрэй. Ганболд гишүүний асуултад хариулъя. Болорчулуун сайдын микрофоныг өгье.

**Х.Болорчулуун:** Зүүн, баруун чиглэлээр мал мах гаргах асуудлыг Гадаад явдлын ямаараа дамжуулаад Хятадын талд тавьчихсан байгаа. Энэ Хятадын талаас л хариу нааштай ирэх байх гэж бодож байна. Бас Хятадын талтайгаа ингээд зохицож 2 талд боомт нээхгүй бол амьд мал гаргах ч байлаа, одоо энэ лабораториос авхуулаад бас нэлээн нэмэлт хөрөнгө шаардлагатай байдаг юм байна лээ.

Ер нь амьд мал өөрийн чинь хэлдгээр бас тодорхой хувь хэмжээгээр гаргах хэрэгтэй. Тэр нь нийт бог малын 5 хувиас хэтрэхгүй ч юм уу, 10 хувиас хэтрэхгүй ч юм уу. Үүнийг бас Хүнсний аюулгүй байдлынхаа зөвлөл энэ тэрээр яриад бас тогтчихъё гэсэн ийм бодолтой байгаа, 1.

2 дугаарт, тэр үхрээс бусад бүх төрлийн малын махыг квотгүй болгосон. Үхрийн махыг одоо энэ хуралдах хурлаар энэ 7 хоногт хуралдах хурлаар үхрийн махыг нь квотыг нь ер нь авах уу, хэвээр нь байлгах уу. Энэ асуудал яригдана. Авсан ч болохгүй юм байхгүй гэж бодож байгаа юм.



2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхдээ үхрийн махыг чанасан болон түүхий махны юу гэж нэг квот гэж гаргаж өгч байгаа юм. Тэгээд ер нь яах вэ, нөгөө талаас энэ хаврын байдлаар харахад махныхаа экспортыг зогсоогооч ээ. Мах үнэтэй болчихлоо гээд л хаширч байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь бас яг бүр квот болгоод энэ үхрийн махтай харин яах бол доо. Ямар ч байсан маргаашийн хурлаар шийднэ, ярилцана гэсэн. Та нар бас саналаа хэлээрэй. Энэ Байнгын хорооны гишүүд, өнөөдрийн хурлаар ч гэсэн.

Тэгээд ер нь өвөлжилтийн бэлтгэл гэсэн мал эмнэлгийн даргын энэ тэрийг суулгах байсан байна даа. Ер нь бас энэ малын өвчинтэй холбоотой их асуудал яригдаж байна. Тийм.

Ганболд гишүүний хэлдгээр ер нь энэ улсын нөөц бол яг яах вэ, ажил үүргийн хуваариар бол журамдаа тэр Шадар сайдын юунд хамаарчихсан байгаа. Хуучин бол ХААЯ-ны сайдын юунд байсан, тэгээд энэ нь бас нэг яг амьдрал дээр бас ийм нэг зөрчил шаардлагыг бас сайн хангуулахгүй ийм байдал бий болоод байгаа юм. Үүнийг бас асуудлыг бас ярина гэж.

Тэр улсын нөөцөд өвс авахгүй, зөвхөн тэжээл авах байгаа. Тэр тэжээлийн нөөцийн төсөв Шадар сайд дээр хамрагдаж байгаа гэдгийг бас хэлье.

**Б.Саранчимэг:** Болорчулуун сайд аа. Тэгээд яг өвс тэжээлийн асуудал угаасаа танайх бодлогоо гаргаад энэ дээр ганц тэр Шадар сайдын асуудал гээд ингээд өөрөөсөө түлхээд явж болохгүй. Яг үүнийг бас яаж нөөцөлж авах вэ? Одоо жишээ нь ногоон тэжээлийг зөндөө олон хүмүүс тарьчихсан байна. Үүнийг яаж бас төрийн бодлогоор хамтарч ажиллах вэ гэдэг юмыг гаргаж ирэхгүй бол зүгээр миний мэдлийн биш ээ, энэ чинь Шадар сайд гээд дахиад ингээд энэ нөхцөл байдал чинь ямар байгаа билээ. Баруун аймгуудаас эхлээд л өнөөдөр

өвөлжилтийн байдал муудаад ирж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр анхаараарай.

Тэгээд Ганболд гишүүн тодруулъя.

**Г.Ганболд:** Нөөцөд яагаад өвс авахаа больчихсон юм гэхээр өмнө нь энэ улсын нөөцийн салбарууд чинь энд тэндхийн өнжсөн олон жил болсон өвснүүдийг шахаад байсан учраас л больсон шүү дээ. Баруун аймгийн Дорнодын ноднингийн хураасан, уржнангийн ус хураасан цагаан өвснүүдийг шахаад байсан учраас больсон юм. Тэгээд би төсвийн хэлэлцүүлэг дээр үүнийг буцаж ярина. Бас манай Байнгын хорооны гишүүд дэмжээрэй гэж хүсэх гээд байгаа юм. Ер нь ХААЯ дээр гаргах хэрэгтэй.

Түүнээс гадна энэ танай энэ корпорац дээр ер нь өнгөрсөн жилүүдэд энэ нэг баахан нөөцөлж байгаа энэ хүнсний улаан буудай, үрийн буудайнууд чинь шаардлага хангахгүй жил болгон тэгээд л дараа нь энэ гурилын үйлдвэрүүд голдог, энд тэндхийн нэг шахаасны юмнууд байдаг гэдэг хэл ам дүүрэн байгаа. Тийм учраас энэ жил энэ намрын энэ үр тариаг нөөц авалт дээр Байнгын хорооноос заавал эд нар ажлын хэсэг гарч энэ нөөцийн газруудад авч байгаа будаануудын чанар дээр хяналт тавина шүү. Түүн дээр Байнгын хорооны дарга бас нэг ажлын хэсэг байгуулаад яг тэр авах үед нь юу ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Ойлголоо. Тэгье, тэгье энэ дээр бас ажлын хэсэг гаргаад явъя. Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Хуучин нийгмийн үед ХААЯ өвс тэжээлийг бүгдийг нь базаж, хангуулж, нөөц бэлтгүүлдэг байсан. Одоо бол зах зээлийн нийгэмд ялангуяа тэр ажил үүргийн хуваариар бол аймаг, сумын сум өөрөө аюулгүй нөөцийг бүрдүүлэх ийм хууль журамтай. Түүнд ХААЯ бүрдүүлэхгүй ээ гэдгийг бас хэлье.

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Харин ХААЯ бол Хөдөө аж ахуйн газраар дамжуулж ногоон тэжээл хэдэн га-д хаана тарьсан. Ямар компани ногоон тэжээлээр хангах боломжтой, үүний мэдээллээр хангаж аймаг, сумыг холбож ажиллах үүрэгтэй. Түүнээс биш нөөц бүрдүүлэх ийм үүрэг байхгүй шүү.

**Б.Саранчимэг:** Нөөц бүрдүүлэх, бүрдүүлэхгүй дээрээ биш. Ер нь Хөдөө аж ахуйн яг энэ салбарын яам бол бас бодлогоо гаргаад хамтраад яаж энэ уялдаа холбоотой ажиллах вэ гэдгийг анхаарч ажиллаарай. Өнөөдрийн бас гишүүдийн энэ хэлсэн саналуудыг ажил үүрэгтэй оролцуулж яваарай. Тэгэхгүй тэгээд нэг нэг рүүгээ чихээд яг энэ өвөлжилт хэцүү болоод ирэхээрээ анхаарахгүй бол болохгүй шүү.

Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. ХХААХҮЯ-аас нэг ганц 2 асуулт асууна гэж байгаа.

1 дүгээрт, бид нар эрх зүйн орчноо тодорхой болгомоор байна. ХХААХҮЯ гэж ийм нэртэй. Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хууль байхгүй. Тэгээд энэ асуудлыг Болорчулуун сайдад бас урьд нь хэлж байсан. ХХААЯ-ны Дондог хэн билээ, түүнд бас хэлж байсан. Тэгээд энэ бүрэн эрхийн хугацаанд энэ хууль орж ирэхгүй байсаар байгаад л ингээд л өнгөрөх л юм байна л даа. Үгүй ээ, тэгээд юугаараа ХХААХҮЯ гэж. Бид нар эрх зүйн орчноо тодорхой болгож байж хуулиа гаргаж байж бүхэл бүтэн яам ажиллаж байгаа биз дээ. Тэгээд энэ хуулиа яаралтай оруулж ирмээр байна шүү дээ.

Тэгээд ингээд юмыг нь үзэхээр дандаа л нэг газар тариалантай холбоотой, МАА-тай холбоотой нэг ийм л юм асуудлаар яриад байна. Бид нарын яриад байдаг нөгөө хувцсаа хийх асуудал юу болж байна. Нөгөө сүү, цагаан идээ, тараг хүнсний ногоогоор хангах асуудал юу болж байна. Нөгөө гутлын үйлдвэр

гээд. Бид чинь ер нь үйлдвэрлэгч улс болъё энэ аж үйлдвэрийг бий болгоё гэдэг асуудал дээр л Монгол Улсын Засгийн газар зорьж яваа биз дээ. Энэ аж үйлдвэрийн сэргэлт хаана яваа юм, энэ хууль байхгүй. Тийм учраас энэ хуулийг хэзээ оруулж ирэх юм бэ?

2 дугаарт, энэ хүнсний хангамж аюулгүй байдал дээр 1,6 их наяд төгрөг ч билүү шийдсэн. Тэгээд энэ асуудал чинь энэ хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хэд нь оногдчихоод байгаа юм. Энэ мах боловсруулах үйлдвэр байж байна. Гурилын үйлдвэрүүд байж байна. Энэ хувцасны үйлдвэр, гутлын үйлдвэр, сүүний үйлдвэр, тарганы үйлдвэр гээд хүнсний үйлдвэр гээд яг ийм нарийвчилсан тоо байвал хэлж өгөөч. Хэдэн хувь нь эдийн засгийн эргэлтэд орчихоод байгаа юм.

Одоо бид нарын энэ нэг жижиг дунд гэдэг ярьдаг юмаа болимоор юм байгаа юм. Энэ жижиг дунд чинь өсөөд дандаа хөнгөн үйлдвэрлэл болчихоод байна шүү дээ. Монгол Улсын Ерөнхийлөгчтэй бүх үйлдвэрүүдээр явсан. Нийтдээ нэг 60 гаруй үйлдвэр ч гэнэ үү, 30 гаруй үйлдвэрүүдээр явсан. Ихэнх үйлдвэрүүд маань жижиг дунд гэдэг энэ зүйлээс халиад голдуу хөнгөн үйлдвэрлэлийн энэ категорит орчихоод яваад байгаа шүү дээ. Тэгээд хаана байна, хөнгөн үйлдвэрлэл гээд энэ дээр чинь бичсэн ганц үсэг алга байна шүү дээ. Тэгээд яам нь болохоор Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн яам гэдэг ийм байдлаар цаашидаа явмааргүй байна.

Тийм учраас энэ газрын дарга нар, сайд нь сууж байна. Яаралтай энэ Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулиа оруулж ирээч ээ. Энэ намрын чуулганаар оруулж ирээд батлаач. Тэгээд энэ хууль, эрх зүйн орчинтой байж бид нар цаашид аж үйлдвэржилтийн асуудал ярина. Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлээд явж байгаа. Шинэ сэргэлтийн бодлогын нэг асуудал аж үйлдвэрийн сэргэлтийн асуудал байж

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа. Энэ бол үндсэндээ орхигдсон байна шүү. Энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ гэдэг 2 дахь асуудлыг тавимаар байна.

3 дахь асуудал бол энэ хөдөөгийн сэргэлттэй холбоотой асуудлууд нэлээн ярьж байгаа. Ялангуяа энэ говийн бүс рүү энэ хүлэмжийн аж ахуйг чиглүүлье ээ гэдэг асуудлыг бас нэлээн ярьсан. Ер нь Их Хурлын гишүүд ч гэсэн шинэ хөдөө гэдэг төсөл дээрээ хүлэмж газар тариалан, багаж тоног төхөөрөмж, трактороор бас хангаад явж байгаа. Үүнийг ер нь 2024 онд яаж өргөжүүлэх ёстой юм. Яамны бодлого юу байгаа юм. Ер нь хүлэмжийн аж ахуйг хамгийн их эрхлэх бололцоо боломжтой газар говь оо гэдэг нь тодорхой болчихсон шүү дээ. 2 сарын өмнө тариалалтаа эхэлдэг, 2 сарын дараа тариалалтаа авдаг гээд. Тийм учраас энэ дээр ер нь ямар бодлого барьж байгаа юм бэ гэдэг дээр бас нэг хариулт авъя. Ийм 3 асуудал дээр авъя.

**Б.Саранчимэг:** Говь нутгийг ногооруулах энэ говь нутгийг бас хүнсний хангамжаар хангаж энэ бодлогоор дэмжих ажил бол бас Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бас Байнгын хороо болон энэ яамны чухал ажил. Тэгэхээр энэ дээр тэр хөнгөн үйлдвэртэй холбоотой салбарын хуулиудыг оруулж ирэх нь яамны үүрэг ээ. Тэгээд 36 дугаар тогтоол батлагдаад яг зохицуулах ёстой хууль, эрх зүйн орчныг сайжруулах хуулиудыг яг ямар хуулиуд орж ирэх вэ гэдгийг яаманд үүрэг даалгавар өгчихсөн. Ганц ч хууль орж ирээгүй. Ганц Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хууль ороод ирчихсэн байсан. Өмнө нь тэр Мэндсайхан сайдын үед орж ирсэн. Эргүүлээд татна гэсэн нь эхлээд барьсан, тэгээд дахиад оруулаад ирлээ дахиад татна гээд л ингээд иймэрхүү байж болохгүй шүү дээ. Тэгээд энэ бид нарын намрын энэ отгон чуулган болж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хуулиудаа яаралтай оруулж ирж яг ингээд л чуулган дуусах болохоор бас бөөгнөрүүлэх биш энэ хуулийнхаа хэрэгжилтийг бид нар хангаж

ажиллах учиртай учраас энэ Энхтүвшин даргын гишүүний яриад байгаа тэр хууль хэзээ орж ирэх вэ? 36 дугаар тогтоолтой холбоотой хууль яг хэзээ орж ирээд хэдэн хууль нь орж ирэх юм бэ? Нэг хууль өргөн барьчаад тэр нь наашаа ч орж ирээгүй л байж байна шүү дээ. Тэгээд энэ дээр бас нэмж хариулаарай.

Сайд хариулах уу? Болорчулуун сайд.

**Х.Болорчулуун:** Манай ХХААХҮЯ-нд ер нь хамаарахгүй салбар ер нь байхгүй болчихсон юм байна лээ. Би энэ дээр бас ингээд нэлээн, өнгөрсөн энэ өвөл Германд болсон Хөдөө аж ахуйн сайд нарын уулзалт зөвлөгөөн гэж болдог юм. Түүн дээр манайх шиг ХХАА хөнгөн гээд ийм 3 том салбарын ялангуяа хөнгөний салбарыг хамруулсан нэг ч яам байхгүй. Зөвхөн ХАА, хүнс эс үгүй бол ХАА загас агнуур гэх жишээтэй байх жишээтэй. Би тэгээд эндээс бүр нэрээр нь хараад манайх бас энэ хөнгөн гэдэг том аж үйлдвэрийн том салбараа энэ бас ХАА-даа цуг хавсруулаад ингээд нэг дайвар маягтай явсан нь бас нэг аж үйлдвэр хөгжихгүй байхын нэг шалтгаан болсон юм байна гэж бас бодол бас төрсөн. Тэр битгий хэл манай яаманд худалдаа хамрагдаж байгаа, тэр битгий хэл гоо сайхан, үсчин хүртэл хамруулчаж байгаа байхгүй юу. Тэр бол нийгмийн хөдөлмөрийн нийгэм рүүгээ л явах ёстой байхгүй юу. Үүнийг бас засаг дарга бас ярьсан байгаа гэдгийг бас. Энэ ч яах вэ тэгээд, энэ хүнсний хангамж аюулгүй байдлын 36 дугаар тогтоолын хүрээнд 5 жилийн хугацаанд 1,7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байгаа. Энэ дээр хөнгөний салбар оруулах заалт байхгүй. Тэгээд арьс, шир, ноос ноолуурт оруулах заалт байхгүй, зөвхөн хүнс болон ХАА байгаа. Энэ тогтоолоороо тийм болохоор энэ хөнгөлөлтийн юунд шууд хамрагдах ийм боломжгүй юм. Тусдаа л энэ аж үйлдвэрээ хөгжүүлэх энэ хөнгөлөлтийн бодлого, дэмжлэг, импортын болон бусад татварын асуудал яригдах нь зүйтэй. Тийм учраас өөрийн

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

чинь хэлдгээр Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийг яаравчилж бид нар оруулж ирэх дээр онцгой анхаарч ажиллая гэдгийг бас хэлэх байна. Та бас Байнгын хорооны даргын хувьд санаа зовж байгаа нь аргагүй ээ гээд хэлье.

Говийн тэр хүлэмжийн талаар нэмж хариулья, Есөн-Эрдэнэ дарга.

**Б.Саранчимэг:** 2 номерын микрофоныг өгье. Тэгээд хууль, эрх зүй хэзээ, хуулийн төслүүд хэзээ орж ирэх вэ тал дээр бас яриарай.

Энхтүвшин гишүүний асуултад хариулья. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ.

Энэ гишүүний саналтай нэг байна. Манай яамны зүгээс бодлого ч бас тийм байгаа. Энэ говийн бүсэд дулааны баланс өндөртэй, даруй төвийн бүсээс 1 сарын өмнө тариалалт хийх боломжтой бас сар гаруйн хугацаатай ургацаа хурааж авах ийм боломжтой байгаа. Энэ хүрээнд бас бодлого төлөвлөлтүүд ингээд явж байгаа. Энэ жил гэхэд говийн бүс болон Дундговь болон Дорноговь аймагт жимсний энэ суулгац үржүүлгийн төв үрслэгээ бойжуулах энэ төвүүдийг байгуулах энэ ажлууд улсын төсвийн хөрөнгөөр бас хийгдсэн. Тус бүр 250 сая төгрөгийн өртөгтэй.

Мөн гишүүн бас их яг энэ асуудал дээр бас онцгой анхаарч 1 тэрбум төгрөгөөр 350 ширхэг ийм хүлэмжийг бас энэ байгуулж өгсөн. Цаашидаа энэ говийн бүсэд хүлэмжийн аж аж ахуй байгуулах чиглэл дээр бас техник технологийн энэ сургалтууд сургах, ялангуяа эрт үрслэгээ бойжуулаад бусад төвийн бүсэд хангах чиглэлээр ингээд ажлууд бас ингээд хийгдэхээр бас ингээд төлөвлөж байгаа.

Мөн ТЭЗҮ зураг төсвийг говийн бүсэд өвлийн хүлэмжийн аж аж ахуй байгуулах ТЭЗҮ зураг төсвийг бас боловсруулсан байгаа.

**Б.Саранчимэг:** Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Газар тариалан, МАА-н салбарын өвөлжилтийн бэлтгэл гээд л жил бүхэн л ярьдаг л даа. Нөгөө нэг намрын дараа өвөл болдог, өвөл болохоор хүйтэн болдог гээд үгтэй. Тэгээд үүнийг яг үнэндээ бид нар бас 21 дүгээр зуунд 1 ийм байгалийн хараат байдал яг л нэг зуунаар мянганаар дамжаад ирсэн энэ л нөхцөл байдал дээрээ яг л хэвээрээ л ингээд л ажиллаж байна л даа. Тэгээд ХХААЯ гэдэг яам нэг ийм тайлан бэлтгэдэг яам бололтой юм шиг байгаа юм. Тэнд тэнд тэдэн тонн өвс бэлджээ, тайлан бэлтгэдэг. Уг нь бодлогын яам байх ёстой байх. Тэр бодлого маань хаана яваад байгаа юм бэ? Жишээ нь энэ МАА-н салбарын энэ өвлийн бэлтгэл гээд л баахан юм ярьж байна. Харин үүний чинь цаана бодлого гэвэл тэр усалгаатай тариалан, усалгаатай малын тэжээл бэлтгэх, услалтын системүүдийн асуудал гээд энэ зүйлүүд чинь өөрөө МАА-н салбарын өвлөөс үл хамаарах, түнээс байгаль нь нэг жаахан өвс өгөх юм уу, өгөхгүй юм уу, бороо орох юм уу, орохгүй юм уу. Түүнээс хамаараад хэдэн тонн өвс бэлтгэе гээд ингээд тэнгэр хараад суугаад байх юм уу, энэ 21 дүгээр зуунд.

Нөгөө технологийн шийдлүүд нь хаана байх юм. Газар тариалан гээд л бас баахан ингээд л статистик мэдээ. Яг энэ газар тариалан дээр ингээд үнэ харахаар дэлхийн зах зээл дээр улаан буудайны үнэ тонн нь 200 доллар буураад болчихсон юм байна. ОХУ-д 100 гаруй доллар болчихсон юм байна. Гэтэл энэ хэвлэлээс харахаар манай ХААЯ 920-оос сая 100 мянган төгрөгөөр улаан буудай худалдаж авна аа гээд тавьчихсан. Энэ нь 300 доллар. Бод доо, дэлхийн зах зээл дээр 200 доллар байна, Орост 100 доллар байна, манайх 300 доллароор худалдаж авах юм байна. Үүнийг чинь дагаад яадаг вэ нөгөө гурилын үнэ чинь л өснө биз дээ. Тэгэхээр үүний цаана бодлогын ямар шийдэл энэ татаасууд чинь ер нь хөгжил дэвшилд хөтөлж байгаа юм уу. Энэ ард иргэдэд

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ашиг тус авчирч байгаа юм уу. Дэлхийн зах зээл дээр 200, Орост 120 доллар байгаа улаан буудайг бид нар 300 доллароор аваад тэгээд дөрөв 500 долларын үнэтэй гурил гаргаад ард түмэнд өгөөд суугаад энэ нь өөрөө энэ салбарын бодлогын шийдэл чинь мөн юм уу? Энд эдгээр асуудлуудад томоохон хариулт бодлогын хариулт өгч тэр МАА-н салбарт хэрхэн яаж, хөдөө аж ахуйн салбарт хэрхэн яаж техник технологи дэмжихийг бодлогоор бид нар урамшуулах юм. Энд яаж бүтээмж дээшлэх юм? Энд яаж цалин, орлого нэмэгдэх юм. Ингэснээрээ эргэж яаж хөрөнгө оруулалт бий болох юм. Энэ бодлогын шийдлүүд энэ зүйлүүд дээр ерөөсөө байхгүй. Нэг өвөлжилт хаваржилтын тоо статистик мэдээ нэгтгээд мэдээг ингээд тэгж тэр тийм тийм газарт зуншлага, намаржилт тааруу байсан. Үгүй ээ энэ чинь тэгээд яах вэ дээ, тэгээд зуунаар, мянганаар ингээд л яваад л ир ирсэн шүү дээ.

Тэр бодлогын өөрчлөлт гэдэг зүйл яг хаана байгаа юм бэ? Үүн дээр нэг ийм хариулт өгөөч. Энэ дээр байхгүй өөр зүйл дээр тэр нь тусдаа явдаг юм уу, бүү мэд.

**Б.Саранчимэг:** Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Цогтгэрэл гишүүн бүхэл бүтэн яамыг тайлан мэдээ нэгтгэдэг яам мэтээр ярьж байна. Олон бодлого гарч байгаа. Та өөрөө мэдээлэл, мэдлэг энэ тал дээр дутуу болохоор бас ингэж хэлж байгаа байх. Танд МАА дээр, газар тариалан дээр, үйлдвэрлэл дээр ямар бодлого явж байгааг тусгайлан бас яаман дээр бас урьж энэ бодлогыг танилцуулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Түүнээс биш шүүмжлэхэд амархан л даа.

Энэ 30 жил яг үнэндээ манай орон бол хэрэглэгч орон байсан үйлдвэрлэлийг дэмжих бодлого явуулаагүй. Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам бол үйлдвэрлэл дэмжих, дотоодын үйлдвэрлэл

хамгаалах бодлого явуулж байгаа гэдгийг бас хэлье.

Татаасны талаар яриад гадаад зах зээл дээр жишээ нь буудайн үнэ тэд байхад 300 доллароор авах үнийг гаргалаа гэж байна. Бид нар үнэ тогтоохгүй. Зүгээр хуучин өрөндөө улаан буудай авах энэ юуг л сангаас гаргасан байгаа. Ер нь аливаа улс орон стратегийн хүнсээрээ гаднын хараат байхгүй байхыг чухалчилж хичээдэг. Түүнээс яг гадаад оронтой зэрэгцүүлээд бид нар бас үнийг бас тийм байлгахыг хичээх юм бол утга учиргүй. Яагаад гэвэл бид нар жишээ нь ОХУ-аас техник, түли, шатахуун, бордоо бүгд үнэтэй хэрэглэж байгаа. Би ганцхан жишээ хэлэхэд Япон улс дотооддоо цагаан будаа тарих нь Хятадаас импортлоор авснаас 2 дахин үнэтэй байдаг. Тэгэхэд үүнийг бодлогоор дотооддоо тарихыг чухалчилж, Хятадаас ингэж дийлэнхүү импортлодоггүй гэдгийг ойлгож байгаа байх.

Ялангуяа улаан буудай бол манай стратегийн хүнс. Гурил улаан буудай, энэ дээр бас төрийн бодлогоор бас дотоодын үйлдвэрлэл хамгаалахгүй бол зүгээр сул тавиад, дэмжлэг өгөхгүй ингэж явал энэ салбар элгээрээ хэвтэнэ. Ер нь хэвтүүлэх ч шахаж байсан, гаднаас та бүхэн мэдэж байна шүү дээ. 3 жилийн өмнө 220 мянган тонн буюу дотоодын улаан буудайнхаа 70 хувьтай тэнцэх хэмжээний улаан буудай импортлоор оруулаад дараа жилээс нь тарих газар тариалан улаан буудай 100 мянган га-аар багасаж байсан шүү дээ. Тэгэхээр ХХААХҮЯ бол мэдээж хэрэглэгч, ард иргэдээ ч бодолгүй яах вэ. Үндэсний үйлдвэрлэл хамгаалах, хөгжүүлэх ийм бодлого дээр ажиллаж байгаа гэдгийг бас хэлэх байна.

**Б.Саранчимэг:** Цогтгэрэл гишүүн тодруулъя гэж байна.

**О.Цогтгэрэл:** Гэхдээ л одоо зах зээлийн үнэд ХААЯ-ны тэр Тариалан эрхлэлтийг нь дэмжих сан ч билүү тэнд

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

худалдаж авч байгаа үнэ чинь зах зээлийн жишиг бичиг үнээ зарлаж байгаа. Эндээс ингээд харахаар яалт ч үгүй өнөөдөр гурилын үнэ дэлхийн зах зээлээс лав л 2 дахинаас илүү үнэтэй байх нөхцөл байдлыг л бий болгож байна. Тэр 120 доллар, 200 доллароо бодоод үз дээ. Тэгэхээр энэ бүгд чинь өөрөө бодлогын хувьд яалт ч үгүй үүний цаана, үүний цаана тэгээд дахиад Монголын ард түмэн л хохирч байна шүү дээ. 2 дахин үнэтэй гурил идэж байна шүү дээ. Энэ тэгээд дахиад төрийн бодлого юм уу? Энэ чинь Монгол Улсын иргэд хожих ёстой биз дээ? Тэнд нэг үндэсний аюулгүй байдал аймаар гоё эх оронч, гоё санаачилгуудын ард талд баахан халамж татаас тавиад, нөгөө талд нь тэгээд дахиад нөгөө иргэд чинь хохирч байх ёстой юу? Тэгэхээр үүний цаана нь яг үүн дээр бодлогын хэлэлцүүлэг, магадгүй бас тодорхой хэмжээний дэмжлэг техник технологийн, бензин тос шатахууны дэмжлэг мэдэхгүй нэг жоохон дэмжлэгүүд байдаг байж магадгүй. Тэгэхдээ энэ чинь өөрөө тэр баланс тэнцвэр чинь яг өнөөдөр алдагдчихаад л байна шүү дээ.

**Б.Саранчимэг:** Ер нь бас нэг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооныхоо хувьд яг харьяалагдаж байгаа 2 яаман дээрээ нэг Байнгын хороогоороо бас нэг очиж ажиллана гэж бодож байгаа. Энэ удаа. Тэгэхээр энэ дээр. Нэмж хариулах уу? Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Дэлхийн зах зээлээс манай улаан буудайн үнэ гурил, улаан буудайн үнэ 2 дахин гэж хэлж болохгүй л дээ. Дэлхийн зах зээл дээр 200 гаран доллартой байгаа. Түүнээс 120 доллартой байхгүй шүү. Тийм, байхгүй. Мэдэхгүй, Оросын улаан буудай хэдэн төгрөг орж ирэхийг өөрөө мэдэж байна уу. 900 төгрөгөөр бүх юм яагаад орж ирэх нь 900 төгрөгөөр үнэ өгч байна. Манайх аравхан хувь илүү буюу 3 дугаар зэргийн улаан буудай нь сая төгрөг, 4 дүгээр зэрэглэлийн улаан буудай 920 төгрөг байгаа шүү. Аравхан хувийн зөрөөтэй,

аравхан хувь битгий хэл хувиар бүх улс орон дотоодын үйлдвэрлэлээ хамгаалдаг. Жишээ нь бид нар Хятад руу боловсруулсан бүтээгдэхүүн оруулахад 60, 70 хувьтай хүртэл ингээд татвараар хамгаалж байна шүү дээ. Яг урсгалаараа тавибал энэ ХАА үнэхээр дорой, богино хугацааны элгээрээ хэвтэнэ. Тийм учраас нь хүнс болон хөнгөн үйлдвэрийн үндэс болдог ХАА тэр сүүн дээр тэр ч, улаан буудай дээр ч тэр, бүх улс орон татаас дэмжлэгийг өгдөг гэдгийг та бас гадарлаж байгаа байх гээд хэлэх байна.

**Б.Саранчимэг:** Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асууж дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн үгээ хэлье.

**Ц.Идэрбат:** Тийм, энэ хөдөө аж ахуйн салбар дээр ялангуяа энэ МАА-н салбар дээр тулгамдаад байгаа л асуудал гэж ингэж харж байгаа. Хөдөөгүүр явахад ч гэсэн үнэхээр энэ нь бодитой байгаа юм. Үүний нэг юм ердөө л малын арьс ширний үйлдвэрлэлийн асуудал байгаа шүү дээ. Одоо бид нар Дарханд хийнэ, Эмээлтэд хийнэ. Би тэрэнд огт түүнд ер нь итгэхгүй байгаа. Малын махны экспортын асуудал бас л хэдийгээр нэмэгдэж байгаа. Ковидын цаг үеийн өмнө түвшиндээ очиж байгаа ч гэлээ гэсэн бидэнд дахиад нөөц байгаа. Тэгээд энэ болгоны л цаашаа үнэ хүрдэггүйн гол шалтгаан бол Био комбинат л юм байна лээ шүү дээ. Ер нь бол малын өвчний асуудал юм байна лээ шүү дээ. Малын мах гарч өгдөггүй, үнэд хүрдэггүй, эрүүл биш байгаад байдаг. Тэгэхээр энэ би үүнийг энэ анх удаа ч ярьж байгаа юм биш. Ер нь энэ Их Хурлын гишүүн болсон цагаасаа л хойш яриад байгаа юм. Энэ малын өвчтэй холбоотой асуудал дээр байнга гаднаас тэр вакцин авна гэж. Тэр чинь маш их хүндрэлийг туулж байж нэг юм малчны хотонд очдог юм шүү. Малын Био комбинат гэж тэр Унгарын Засгийн

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

газраас нэг овоо яригдаж байгаад л байхгүй болсон. Одоо Дэлхийн банк яригдаад байгаа. Тэгээд энэ Био комбинатынхаа асуудлыг 1 номерт эрэмбэлж, үүнийгээ цэгцлээд, малынхаа тарилга юмнуудыг цэгцлээд, отор нүүдлээ цэгцлээд. Ингээд нэг эрүүл малтай гэдэг тодорхойлолт руу орох юм бол энэ малын махны маань үнэ асар өндөр үнэд хүрнэ шүү дээ. Гадагшаа гаргаж байгаа нь сая Батжаргал гишүүний хэлж байгаагаар дотооддоо зарж байгаагаас хямд үнээр бараг гадагшаа гаргаад байгаагийн гол шалтгаан ийм юм билээ.

Тэгэхээр би энэ гадна, дотнын зээл тусламж энээ тэрээ юмнуудыг эхний ээлжид энэ малаа эрүүлжүүлэх юм руугаа бас хандуулбал яадаг юм бэ гэсэн ийм саналыг хэлмээр байгаа юм.

Арьс ширний үйлдвэр арьс шир ч бас малын энэ өвчин хуучинтай холбоотой хачиг хувалзтай холбоотой гээд л үнэд хүрэхгүй байгаа гээд л ингээд. Гол 2 юм нь үнэд хүрэхгүй байгаагийн шалтгаан ердөө малын өвчин. Үүнийг төрөөс зохицуулах төрийн үүрэг бол вакциныг цаг тухайд нь хийх, хангах энэ үүргээ бид гаднаас гуйж хийгээд байхаар үүнийгээ биелүүлж чадахгүй байна л гэж ингэж хараад байгаа шүү дээ. Тэгэхээр юмаа эрэмбэлдэг бол би бүх асуудлын үндэс ялангуяа ХАА, МАА-н салбар дээр үүсээд байгаа энэ үнийн асуудал, экспортын асуудлын гол түгжээ чинь энэ Био кабинет юм байна. Малын өвчний асуудал юм байна. Тарилга, туулгынхаа асуудлыг дотооддоо хэдүүлээ шийддэг болохгүй бол Монгол 70 сая малтай хөдөө аж ахуйн орон гэж байгаа хэр нь бүх тарилга туулгаа дийлэнх нь гадаадаас авна. Оросоос авна, ирэхгүй, тэгээд малаа бид нар тариад л энэ 90 хэдэн хувьтай гэдэг чинь бол яг сонгож авсан тэр голомттой айл өрхүүдийн л 90 хэдэн хувийг нь л вакцинжуулж байгаа болохоос биш бүх малын 90 хэдэн хувь бас биш шүү дээ. Нэг их өндөр дүн л харагдаад байгаа болохоос биш.

Тийм учраас би энэ Био комбинат гэдэг юм эхний ээлжид байж Монгол Улс энэ аюулгүй байдал энэ бүх зүйлээ бас бодсон ч тэр. Би эхний ээлжид энэ Био комбинат юм биш үү. Тэгэхээр гадна дотнын янз янзын зээл тусламжуудыг өнгөрсөн хавар чуулганы хуралдаанаар орж ирэхэд тэр нэг сургагч багш бэлтгэнэ энэ тэр гэсэн нэг ийм аахар шаахар үр дүнгүй юманд аваачиж хийж байхаар энэ Био комбинат гэдэг зүйлээ яриа ч ээ.

Тэгээд энэ Байнгын хорооноос ер нь Био комбинаттай газар дээр нь очиж би бол танилцамаар байна гэсэн ийм хүсэлтийг бас тавимаар байгаа юм. Тийм. Баярлалаа.

Тэгээд Био комбинат. Дээрээс нь тэр мал эмнэлгийнхэнтэй. Яг энэ 2-ын ажлын уялдаа холбоо нь ямар юм байдаг юм. Хэчнээн хэмжээний тариа тарилга үйлдвэрлэдэг юм. Хэдийг нь экспортоор авдаг юм. Ямар ААН-үүд байгуулдаг юм. Одоо нууцын зэрэглэлд оруулаад шууд хийчихдэг эд нар гээд ингээд гадуур янз янзын л юм яваад байна шүү дээ, бас л. Баярлалаа.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Тэгэхээр тэр вакцинаа ч гэсэн хугацаанд нь хийх талаар ер нь гишүүдийнхээ энэ саналуудыг манай яам маш сайхан сайн тэмдэглэж аваад үүнийхээ гүйцэтгэл тал дээр бас манайд ирүүлээрэй.

Одоо Батжаргал гишүүн үгээ хэлье, саналаа хэлье.

**Ж.Батжаргал:** Тийм. Тэгэхээр энэ эдийн засгийн суурь салбар хөдөө аж ахуйн салбарыг их зөв бодлогоор бид авч явах ёстой. Мэдээж үр өгөөж, үнэ цэнийн тухай ярих ёстой. Сая тэнд Цогтгэрэл ярьж байгаа бол буруу зүйл биш. Гэхдээ бид нэг цаг үед яг ингэж ярьж байгаад хамгийн хямд газраас юмаа авчраад хийчихдэг юмаа гэж хэлж байгаа гээд газар тариалангийн салбараа унагачаад бүхэл бүтэн 20 гаран жил ноцолдож

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байж өдий зэрэгт тасарсан байхгүй юу. Тэгэхээр энэ рүү хөлбөрч болохгүй. Үүн дээр бодох ёстой. Гэхдээ үр өгөөж яаж гардаг вэ гэхээр зэрэг нэгжээс авч байгаа бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх замаар л бий болгодог. Тэгэхээр бидэнд үрийн шинэчлэлийн тухай асуудал руу онцгой анхаарахгүй болохгүй болчхож байгаа байхгүй юу. Наад төмсөө хар, нэгжээс энэ жил хэд авч байна. Далан хэдэн центнерийн тухай л ярьж байна шүү дээ. Хуучин хэд авдаг байсан бид, 100 гаран центнертэй яригддаг байсан. Тэгэхээр төмсний үрийн шинэчлэлийн асуудал хийхээс арга байхгүй.

Улаан буудайгаа хар. Тодорхой өвчлөл байна гэдэг юм тогтоогдоод байна. Мэргэжлийн яам юу бодлогын яам энэ асуудлаа бүтэн нягталж үзээд ирэх жилийн тариалалтууд дээр үрийн тал дээр, ургамал хамгааллын тал дээр ямар бодлого барьж явах вэ гэдэг юмаа тодорхой болгож агро технологийнхоо удирдамжийг их тодорхой болгохгүй бол бас бидний наад өртөг зардлын асуудал чинь яригдана. Тийм учраас үүнийгээ нэг бодох зайлшгүй шаардлага байна.

3 дахь зүйл, энэ механикжуулалтын бодлогыг бид хийхээс арга байхгүй. Одоо энэ хүнсний ногоо төмсийг хураах гээд л баахан цэрэг, оюутан татаад л байдаг. Үгүй ээ, ингээж явдаг орон хэр олон байгаад байгаа юм. Тэр 2 мөрөөр нь гэдэг юм уу шууд хураагаад савлаж чаддаг хэмжээнд технологийн, техникийн шинэчлэлийг нь хийж чадах юм бол бид ажиллах хүчийг эрс бууруулаад, үр өгөөжийг дээшлүүлэх бололцоо байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ рүүгээ бүхэл бүтэн яамны тэр газар энэ зэргэлдээх улс орнууд руугаа явж ямар техник нь Монголд нутагшиж болох юм. Бүтээмж өсөж болох юм гэдэг юмаа тогтоогоод түүнийгээ түрүү талаас нь оруулж ир л дээ. Тэгээд түүнийгээ үйлдвэрлэлд нэвтрүүлээд үр өгөөж байна гэдгийг нь харуул л даа. Тэгээд цааш нь борлуулалтынхаа асуудлыг өргөжүүлбэ л дээ. Ингээж л авч

явахгүй бол энэ салбарт үнэхээрийн байдал тийм амаргүй байгаад байгаа гэдгийг би зориуд хэлмээр байна.

Дараа нь урамшууллын бодлого дээр бид бодох ёстой. Хүнсний ногооны урамшууллыг бид жигд тонн тутамд тэдэн төгрөг гэж хэлж болохгүй юм байна лээ. Ямар хэмжээний ургац ямар хугацаанд өгдөг таримлууд байгаа билээ. Үнэхээрийн л үүгээр бид дотоодынхоо хэрэгцээг хангана гэж байгаа бол түүн дээрээ урамшууллын өөр бодлого явж байж, наад хүлэмжийн аж ахуй чинь жсоохон урагштай явах юм байна лээ. Бүтэн жил ноцолдоод 5 тонн өгдөг ургацтай аж ахуй дээр тонн тутамд нь 100 мянган цаас өгөхөөр чинь 500 мянган цаас л байгаад байгаа шүү дээ. Гэтэл нэгжээс 240 центнээрээр авдаг юм чинь хэд болж байгаа юм 2,4 сая төгрөгийн урамшуулал болж байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь ийм байдлаар асуудалд хандаж боломгүй. Үүнийг бид их бодож зөв хийх ёстой юм байна.

Өвөлжилтийн бэлтгэл тал дээр бид анхаармаар байна. Байдал тийм амаргүй байгаа. Яг үнэнийг хэлэхэд. Хүйтний улирлын төлөв сая энэ бас Говь Угтаал дээр гарсан улсуудын ярьж байгаа энэ тэрийг бүгдийг нь нэгтгээд дүгнэхээр бас цастай хүйтэвтэр ийм өвөл байх нь уу гэмээр ийм төлөв харагдаад байна. Тийм учраас эртхэн тэр зам даваа элдэв бусын боогдчихоогүй байгаа дээр өвс тэжээлийн нөөцүүдийг зөв байршуулах тухай асуудал байна.

Сум, аймгуудын аюулгүй нөөц бүрдүүлэлт дээр хяналт тавьж ажиллах тухай асуудал байна. Үүнийг шуурхайлахгүй бол болохгүй нь ээ гэж.

Дараагийн нэг зүйл энэ мах бэлтгэлийн асуудлыг бид анхаарахгүй бол болохгүй ээ. Чарган дээр малын хорогдол үүсгэж таарахгүй. Малаа ангил, мах бэлтгэлтэй нэмэгдвэл борлуулалтынхаа асуудлыг хэдүүлээ зөв шийдэх тухай асуудлаа авч үзэх ёстой. Тэгээд ер нь энэ



2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэе гэвэл зарим зүйлүүдийг заавал гаднын нэг зээл тусламж яриад 5, 10 жил болдоо л больчихмоор байгаа юм. Биог яахаараа бид нар дотоодынхоо нөөцөөр өргөтгөж болохгүй байгаа юм бэ. Тодорхой хэсгийг нь яагаад хувьчилж болохгүй байгаад байгаа юм бэ? Үүнийгээ зөв шийдлийг нь менежментийг нь л гаргая л даа. 34 хувийг нь хувьд өгье. Дээр нь өргөтгөлийг нь шаардлагатай мөнгийг нь. Энэ чинь даанч дээ, бүхэл бүтэн улс байна даа. Эдийн засгийнхаа суурь салбар амь амьжиргаа болсон салбарынхаа хөгжлийг тогтвортой хангахын тулд дотоодоосоо яагаад хөрөнгийн эх үүсвэр гаргаж болохгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр ийм юмнуудыг шийдэхгүй бол болохгүй ээ. Яах аргагүй наад вакцинууд гэдэг чинь зүгээр нэг нийлүүлээд тарьдаг юм биш. Дандаа технологийн цаг хугацаатай. Сая энэ улсуудын ярьж байгааг харж байгаа биз дээ. 4 сарын сүүлч, 5 сарын эхээр тарьдаг юмыг 6 сар гарчхаад байхад вакцин нь тарих газраа очоогүй байна гэхээр чинь бид ямар юмныхаа ... /минут дуусав/

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Энхтүвшин гишүүн саналаа хэлье.

**Т.Энхтүвшин:** Тэгээд та бүхэн маань Хөнгөн үйлдвэрлэлийнхээ тухай хуулийг бас яаралтай оруулж ирээрэй. Ер нь бид бас дотооддоо энэ хувцас хунараа хийх, гутлаа хийх, даавуугаа хийх, сав баглаа боодлоо хийх гээд олон зүйлүүдийг бас хийж байгаа шүү дээ. Тийм учраас бид нар энэ Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулиа яаралтай гаргаад эрх зүйн орчныг нь бас тодорхой болгох дээр бас нэлээн анхаараарай.

Одоо хүнсний салбар хүнсний хангамжийг сайжруулах гээд нэг үеэ бодвол бас нэлээн дэмжлэг зээл өгөөд явж байна. Харин яг энэ хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр явж байгаа энэ салбарууд маань нэлээн орхигдоод хоцроод байгаа юм биш үү. Ер нь бид нарын цаашдын гол зорилго

бол ерөөсөө л аж үйлдвэрийг хөгжүүлэх, өөрсдөө бүх зүйлээ хийдэг дээр л эхний ээлжид хүнсээ хийе, дараа нь бүх төрлийн хувцас хэрэглэл, даавуу юу гэдэг юм гутал хувцас гээд бүгдийг нь хийе ээ гэдэг ийм асуудал ярьж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ хуулиа нэг яаралтай оруулаад ирээрэй. Харин энэ хууль дээрээ аль ч салбар нь ХХААХҮЯ-д хамаарах ёстой юм. Аль салбар нь уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн яаманд хамаарах ёстой гэдэг дээр нь зааг ялгаатай ийм хуулийг яаралтай өргөн бариарай л гэж хүсэж байна. Амжилт хүсье.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Тэгэхээр өнөөдрийн энэ Байнгын хороонд манай хэлсэн гишүүдийн саналуудыг маш тодорхой протоколд тусгачихна. Тэгээд үүний дагуу та хэд маань бас хийсэн ажлуудаа тайлагнаад манай Байнгын хороонд ирүүлээрэй.

Тэгээд ялангуяа тэр говийг бас ногооруулах, говийг хүлэмжээр хангах үүнийг техник технологийн арга зүйтэй болгох тал дээр бас илүү анхаарч ажиллаарай гээд тэрийг бас онцолж хэлэхийг хүсэж байна.

13.12 цаг

Тэгээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хурал дууссаныг мэдэгдье.

Өнөөдрийн хуралд идэвхтэй оролцсон бүх гишүүд, ажлын албаныхан, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ